# СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| № | № | Дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ** | | | | | | |
| **Зорилго:Үндэсний эх хэл, соёл, түүх, уламжлалаа дээдлэн байгальтай зөв харилцах чадварт суурилж, эх орноо хайрлах нэгдмэл үзэл санаатай монгол хүнийг соён гэгээрүүлнэ.** | | | | | | |
| **1.1.Үндэсний бахархал, эв нэгдэл** | | | | | | |
| **Зорилт: Байгалийн унаган төрхийг хамгаалж, уламжлалт ёс заншил, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэн монгол хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, авьяас билгийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.** | | | | | | |
| 1 | 1 | “Алсын хараа-2050”-ийн 1.1.1,.1.1.2, 1.4.1, 1.4.3 МУХТЖҮЧ-ийн 1.2.1, ААЗДҮАХ-ийн 2.4.4 | “Монгол төгсөшгүй, мөхөшгүй, мохошгүй” язгуур урлагийн хамтлагуудын нэгдсэн тоглолтыг зохион байгуулах. | Үзэгчдийн тоо | Сумын ардын авьяастануудын .“**Сар шинийн эгшиглэн**” ардын язгуур урлаг өв соёлын шинэ уран бүтээлийн тоглолтыг бэлтгэн толилуулсан. | 30% |
| **1.2. Нүүдлийн соёл иргэншилт Монгол** | | | | | | |
| **Зорилт: Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.** | | | | | | |
| 2 | 1 | “Алсын хараа-2050”-ийн | “Монгол гэр”-ийн холбоотой ардын мэдлэгийг сургууль, цэцэрлэгээр дамжуулан хүүхэд | Монгол гэрээр хангагдсан сургууль,цэцэрлэгий | Соёлын төвийн хүлээх танхимд монгол гэр ахуй соёлын буланг байгуулахаар төлөвлөн эхний ээлжийн ажлуудыг гүйцэтгэж байна. | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.1.1,.1.1.2, 1.4.1, 1.4.3 МУХТЖҮЧ-ийн 1.2.1, ААЗДҮАХ-ийн 2.4.2 | бүрт өвлүүлэх. | н тоо<br>-мэдлэг олгох арга хэмжээний тоо<br>-монгол гэр барих, буулгах аргад суралцсан сурагчдын эзлэх хувь | СӨБ-өөр дамжуулан цэцэрлэгийн хүүхдүүдэд ардын өв уламжлалаас зааж сургах зорилгоор Монгол гэр, ардын өв уламжлалын буланг тохижуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>Мөн сар бүр “Монгол гэр” сэдвийн хүрээнд монгол ёс уламжлал, зан заншил, ахуйн орчин соёлын талаарх мэдлэгийг олгож байна. | |
| 3 | 2 | “Алсын хараа-2050”-ийн 1.1.1,.1.1.2, 1.4.1, 1.4.3 МУХТЖҮЧ-ийн 1.2.1, АХТЖҮЧ-ийн 1.2.3 ААЗДҮАХ-ийн 2.4.2 | Насан туршийн боловсролын төв, нэгжийг түшиглэн байгууллага, хамт олон, иргэдэд зориулсан монгол бичгийн сургалтыг зохион байгуулах, үр дүнг тооцох. | Үндэсний бичиг үсэг сурсан хамт олон, иргэдийн тоо | Хэрэгжээгүй | 0% |
| 4 | 3 | МУТЖҮЧ-ийн 1.1.4, ЗГҮАХ-2.6.3 АЗДҮАХ-ийн 2.4.7 | Аймаг, сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамгаалуулах. | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалсан хувь | Сумын засаг даргын 124/А захирамжаар 18 иргэн, ААН-д 153 ТСҮХДГазрыг хариуцан хамгаалах гэрээг шинэчлэн байгуулсан.<br>Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрын улсын тооллогоор сумын нутаг дэвсгэрт байгаа улсад бүртгэлтэй 207 ширхэг түүх соёлын дурсгалт зүйлс, газрыг тооллогод хамруулсан.<br>Тооллогын үеэр сумын Атар, Сангалтай гэх газарт орших 1 зосон зураг, нарийн шүрэнгийн 4 хиргисүүр, Хуурчийн хөндийд байрлах 8 ш дөрвөлжин болон дугуй булшийг олж, бүртгэн баримтжуулж авсан. | 100% |
| 5 | 4 | МУТЖҮЧ-ийн 1.1.4, | Баримтат өвийн бүртгэлийн нэгдсэн системийн үйл | Бүртгэн баримтжуулсан | Зохиолч Ч.Лувсанжавын 2 номын ховор баримтат өвд бүртгүүлэхээр судалгаа хийж | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ЗГҮАХ-2.6.3, АЗДҮАХ-ийн 2.4.7 | ажиллагааг шинэчлэх. | өвийн тоо | байна. Иргэдийн гар дээр байгаа баримтат өвийн хайгуул судалгаа тогтмол хийгдэж байна | |
| 6 | 5 | МУТЖҮЧ-ийн 1.1.2, 1.2.1, ЗГҮАХ-2.6.4, АЗДҮАХ-ийн 2.4.3 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх. | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн загвар зураглал батлагдсан эсэх | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг эрэн сурвалжлан бүртгэх, сурталчлан алдаршуулах арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд шинээр “ПОЛИМОР” урлал болон “Нэхмэл гутлын” үйлдвэрлэгч 2 өвлөн уламжлагч бүртгэн авч шавь сургалтыг Соёлын төвд 14 хоногийн хугацаатайгаар зохион байгуулж 19 иргэн хамрагдсан. | 30% |
| 7 | 6 | МУТЖҮЧ-ийн 5.3.2, ЗГҮАХ-2.6.2, АЗДҮАХ-ийн 2.4.8 | Соёлын өвийн бүртгэл, хяналтын системийг хөгжүүлж мэдээллийн санг бүрдүүлэх. | Өвийн мэдээллийн бүрдүүлсэн хувь | Сумын Атар, Сангалтай гэх газарт орших 1 зосон зураг, нарийн шүрэнгийн 4 хиргисүүр, Хуурчийн хөндийд байрлах 8 ш дөрвөлжин болон дугуй булшийг олж, бүртгэн баримтжуулж авсан. | 30% |
| **1.3. Монгол хэл, бичиг** | | | | | | |
| **Зорилт: Үндэсний Монгол хэл, бичгээ нийтээр сурч эзэмшин түгээн дэлгэрүүлнэ.** | | | | | | |
| 8 | 1 | МУТЖҮЧ-ийн 2.1.3, ЗГҮАХ-2.3.4 | Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайржуулах. | Үндэсний бичиг үсэг сурсан суралцагчдын эзлэх хувь<br>-Монгол бичгээр сургалт явуулах түвшинд хүрсэн багшийн хангалтын хувь<br>-Төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн шалгалтын улсын дундажаас ахисан хувь | “Үндэсний бичиг соёлын өдөр”-г тохиолдуулан Монгол үндэсний хэл бичгээрээ цэвэр сайхан бичих сурч эзэмших хүсэл эрмэлзлийг бадраах, хөхүүлэн дэмжих, бичих чадварыг нэмэгдүүлэх зорилготой “Сайхан бичигтэн”, ”Цэвэр бичигтэн” шалгаруулах тэмцээн, төрийн албан хаагчид иргэдийн дунд шударга уншлагын тэмцээнийг зохион байгууллаа. Үүнд нийтдээ 106 гаруй иргэн, хүүхдүүд оролцон бүтээлийн үзэсгэлэнг гарган нийтэд үзүүлсэн.<br>Соёлын бүтээлч сарын аяны хүрээнд: “Босоо Монгол бичиг мину” сургааль ,зүйр цэцэн үгсийн уран бичлэгийн уралдааныг хүүхэд, насанд хүрэгчид гэсэн 2 насны ангилаар зохион байгуулан нийт 14 хүүхэд 8 насанд хүрэгчид | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оролцлоо.<br>"Миний нутаг" шүлгийг монгол бичгээр цэвэр сайхан бичих төсвийн байгууллагын ажиллагсадын дунд зохион байгуулсан уралдаанд нийт 26 албан хаагч оролцлоо. | |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | |
| **Зорилго:Иргэдийн эрүүл энх амьдрах, сурах, хөдөлмөрлөх боломжид суурилан нийгмийн баталгааг бий болгоно.** | | | | | | |
| **2.1. БОЛОВСРОЛ** | | | | | | |
| **Зорилт: Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 9 | 1 | МУТЖҮЧ-ийн 2.1.1, ЗГҮАХ-2.3.2, САХТЖҮЧ-ийн 2.1.1, ААЗДҮАХ-ийн 2.4.6 | Зарим цэцэрлэгүүдэд хувилбарт сургалтад 150 хүүхдийг, 5 настай хүүхдийг цэцэрлэгт 100 хувь хамруулах. | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь | СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор 1-р цэцэрлэгээс малчин өрхийн хүүхдүүдэд Нүүдлийн 2 бүлгийг 6 ба 7 дугаар сарууддад 8 долоо хоногийн хугацаанд хичээллэж, СӨБ-д 60 хүүхэд хамрууж хамран сургалтын цэвэр жин 78.2%-д хүргэсэн.<br>Мөн 2 дугаар цэцэрлэгт 24 цагийн бүлэгт болон өдрийн бүлэгт нийт 43 малчин өрхийн хүүхэд суралцаж байгаа бөгөөд хамран сургах тойргийн малчдын зуслангийн Тийрэг хэмээх газарт нүүдлийн цэцэрлэг ажиллуулж малчин өрхийн 18 хүүхдийг хамруулсан. | 100% |
| 10 | 2 | МУТЖҮЧ-ийн 2.1.2, ЗГҮАХ-2.3.3, САХТЖҮЧ-ийн 2.1.2, ААЗДҮАХ-ийн 2.4.4 | Бага, дунд боловсролын чанарын болон суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийж, хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах. | Бага, суурь бүрэн дунд боловсролын шалгуурт суурилсан шалгалт, хөндлөнгийн үнэлгээний гүйцэтгэлийн хувь<br>-Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж онооны өсөлт, бууралтын хувь | Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 47 багш хамрагдсан ба 1-р түвшинд 4 багш, 2-р түвшинд 17, 3-р түвшинд 26 багш үнэлэгдсэн. Үнэлгээг шалгуураар задалбал суралцагчийн сурах үйл ажиллагааны үр дүнгийн ахиц 54.7%, суралцагчийн хөгжил, хамгаалал, төлөвшил 99,1%, багшийн мэргэжлийн хөгжил 91,6%, сургууль олон нийтийн үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр 88,0% үнэлэгдсэн. Элсэлтийн ерөнхий шалгалтад нийт 37 сурагч 7 хичээлээр орсон ба дундаж 481,1% үнэлэгдсэн | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Энэ нь өмнөх оноос 3.6%-аарр өссөн үзүүлэлттэй байна. | |
| 11 | 3 | МУТЖҮЧ-ийн 2.1.7, ЗГҮАХ-2.3.8, САХТЖҮЧ-ийн 2.1.3, ААЗДҮАХ-ийн 2.2.4 | “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх. | Багшийн мэргэжлийг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлсэн сургууль, цэцэрлэгийн эзлэх хувь<br>-Мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн багшийн тоо<br>-Хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүй, тэргүүн туршлага түгээсэн багш нарын эзлэх хувь<br>-Сургалтын шинэ арга зүй, технологи нэвтрүүлсэн багшийн эзлэх хувь | БМДИ-ийн анхны жилийн сургалтад 2 багш цахимаар хамрагдаж амжилттай суралцсан. Мэргэжлийн бүлгийн сургалтад цахимаар 2 удаа давхардсан тоогоор 12 багш, арга зүйч хамрагдсан. БМДИ-ийн сайжруулсан сургалтын хөтөлбөрийн болон сурлагын хоцрогдол арилгах сургалтад 6 багш 1 арга зүйч, ОУ-ын "Эко сургууль, цэцэрлэг" Мөнгөн гэрэгэ хөтөлбөрийн 3 дахь шатны сургалтад танхимаар 3 удаа нийт 15 багш /давхардсан тоогоор/ сурсан. Түүнчлэн ажлын байрандаа цэцэрлэгийн захиргаанаас болон ЗАН-ээс 11 удаа арга зүй, ёс зүй, харилцааны сургалтуудыг зохион байгууллаа. Аймгийн БШУГ-аас зохион байгуулан явуулж буй “Багш миний туршлага” сэдэвт арга зүйн сургалт 2022 оны 3, 4 дүгээр сард нийт 6 удаа чиглэл тус бүрээр зохион байгуулагдан явагдсан. Уг арга хэмжээнд нийт багш нараа бүрэн хамруулан оролцуулж багш нарын заах арга ур чадварыг дээшлүүлэн ажиллаж байна.<br>БМДИ, аймгийн боловсролын газар, сум орон нутаг, байгууллагаас зохион байгуулсан нийт 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор 144 багш хамрагдсан.<br>БМДИ-ийн СӨБ-ын байгууллагын удирдах ажилтны хөгжил хариуцсан арга зүйч багшийн "Тэгш хамруулан сургах боловсролын эрх зүйн орчин", "Боловсролын харилцаа-Багшийн нөлөөлөл", БМДИ-ийн багшийн "Зайн сургалтын онол арга зүй", Нийслэлийн СӨБ-ын мэргэжилтэн багшийн "СӨБ-ын баримтлах бодлого", | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсролын газрын мэргэжилтэн, эрхлэгч нарын хамтран зохион байгуулсан "Хөдөлмөрийн хууль-Хөдөлмөрийн гэрээ", "Мэргэжлийн зэрэг олгох хасах журам", "Хүүхэд хамгаалал", "Цэцэрлэг ЕБС-ийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх журам А\803 дугаар тушаал\", "Байгууллагын хөгжлийн менежмент-Стратеги төлөвлөгөө боловсруулах арга" зэрэг сэдэвт сургалтуудад цахимаар хамрагдсан. | |
| 12 | 4 | МУТЖҮЧ-ийн 2.1.7, ЗГҮАХ-2.3.8, САХТЖҮЧ-ийн 2.1.3, ААЗДҮАХ-ийн 2.2.6 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ялгаатай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлж, суралцагчийн онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, сургалтын орчныг бүрдүүлэхэд бүх шатны байгууллагад дэмжлэг үзүүлэх. | Мэргэжил дээшлүүлсэн багшийн тоо сургалтын орчин бүрдүүлсэн сургууль, цэцэрлэгийн тоо | Мэргэжил дээшлүүлэх үндэсний сургалтад багш нар тухай бүрд нь хамрагдаж байна.<br>1 дүгээр цэцэрлэгийн багш ажиллагсдын санаачилга, хандиваар цэцэрлэгийн бэлтгэл А бүлгийн унтлагын өрөөг шинэчлэн “БИ ӨӨРӨӨ“ өрөөг шинээр байгуулсан. Энэ танхимд хүүхэд өөрөө үйлийн эзэн байж багшийн дэмжлэгтэйгээр өөрөө биечлэн хийж өөртөө үйлчлэх энгийн дадал чадвар, гэр ахуйн хөдөлмөрт суралцаж түүнийгээ гэртээ хариад хийж хэрэгжүүлэх амьдралын ухаанд суралцаж байна.<br>СӨБ-д хамрагдаж байгаа тусгай хэрэгцээт хүүхдийн суралцах үйлийн онцлогт тохируулан дасгал даалгавар, ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. СӨБ-д 6 тусгай хэрэгцээт хүүхэд суралцаж байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдэд зориулан 6 бүлгийн ариун цэврийн өрөөний суултуурын хажуу хаалтад 24 ширхэг бариул суурилуулсан.<br>БНСУ-ын Жежү тусгай мужийн Боловсролын газар, Сэлэнгэ аймгийн БШУГ-ын хамтын ажиллагааны хүрээнд багш, сурагчдын мэдээллийн технологийн чадавхийг нэмэгдүүлэх | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зорилготойгоор мэдээлэл зүйн орчин үеийн тоног төхөөрөмж бүхий тохилог анги танхимаар хангагдсан. Уг ажлын үр дүнд сурагчдын мэдээллийн технологийн мэдлэг, чадвар нэмэгдэхийн зэрэгцээ багш нарын заах арга зүй болон IT мэдлэг дээшлэх ач холбогдолтой юм. | |
| 13 | 5 | МУТЖҮЧ-ийн 2.1.10, ЗГҮАХ-ийн 2.3.12 | Боловсролын цахим шилжилтийн хүрээнд боловсролын салбарын мэдээллийн систем, тоног төхөөрөмж, дэд бүтцийг үе шаттайгаар сайжруулж, цахим сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэх. | Цахим сургалт явуулах боломжтой сургууль, цэцэрлэгийн тоо<br>-Онлайн сургалтад хамрагдсан сурагч, иргэдийн тоо | Ажлын байран дээрээ онлайн олон удаагийн сургалтанд 1045 сурагч, 74 багш хамрагдсан. Анги бүр цахим групп, чат, бүлгээрээ эцэг эхчүүддээ сургалт зохион байгуулж ажилласан. Онлайн сургалтанд давхардсан тоогоор 1045 сурагч түүний эцэг эх асран хамгаалагч нар хамрагдсан.<br>Мөн багш нар хоорондоо мэдээлэл солилцох, хамтран ажиллах үйл ажиллагаандаа google sheet –ийг тогтмол ашиглаж хэвшсэн. | 70% |
| 15 | 7 | МУТЖҮЧ-ийн 2.1.9, ЗГҮАХ-ийн 2.3.10 | Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны өдөрт авбал зохих илчлэг, шим тэжээлийн хэрэгцээг хангахуйц хоолоор үйлчлэх. | Хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх боломж бүрдүүлсэн эсэх. | БШУС, ЭМС-ын 2020 оны 12 дугаар сарын 02 ны өдрийн А/166 А/559/222 дугаар хамтарсан тушаалын 2-р хавсралт "Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ"-г баримтлан хүүхдийн хоолны цэсийг /меню/ долоо хоног тутам ахлах тогооч, эмч, нярав нар хамтран гаргаж, эрхлэгчээр баталгаажуулан өөрсдийн бэлтгэсэн халуун хоол цайгаар өдрийн дэглэмийн дагуу үйлчилж байна. Түүнчлэн орц нормтой уялдуулан ногооны нэр төрөл хэмжээг нэмэгдүүлж вандуй, броккли, яншуй, бууцай, саримсны гол мөн жимс жимсгэнийн төрлөө нэмэгдүүлж алим, чавга, чангаанз, хатаасан жимс зэргээр баяжуулан бүтээгдэхүүн гаргаж байна. Өдөр тутам хоол хүнсээр витаминжуулах зорилгоор бага үдэд аарц, аарцны ундаа, тараг, | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзэмний шүүс, ааруулын шүүс, чацарганын шүүс, хөөрүүлсэн сүү, ус, зөгийн балтай олон жимсний компот хийхээс гадна 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр “Эрүүл хооллолт” сэдэвт амталгаат өдөрлөгийг зохион байгуулж давхардсан тоогоор 186 эцэг эхийг оролцуулж амталгаа хийлгэн санал сэтгэгдлийг нь сонссон.<br>Мөн цэцэрлэгийн гадна талбайд хүлэмж барьж, намар шим тэжээл бүхий шинэхэн нарийн ногоог хоол хүнсэндээ хэрэглэж байна.<br>Хүүхдэд олгож буй хоолноос өдөр бүр дээж авч, хоолны цэсийг сургууль, цэцэрлэгийн эцэг эхчүүдийн цахим хаягт байршуулан ажиллаж байна.<br>ЕБС-ийн 1-5р ангийн сурагчдад 600 ккал, 6-8р ангийн сурагчдад 800-100 ккал, 9-12р ангийн сурагчдад 1600-1750 ккал илчлэг бүхий хоолоор үйлчилж байна. Уг илчлэг бүхий хоолыг дотуур байрны 115 сурагчдад хүргэж байна. | |
| 16 | 8 | МУТЖҮЧ-ийн 2.1.9, ЗГҮАХ-ийн 2.3.10 | Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд хамруулах, мэргэжлийн хүний нөөцөөр хангах. | Хүний нөөцөөр бүрэн хангагдсан сургуулийн тоо | Үдийн цай хөтөлбөрийн хүрээнд сурагчдад хоолоор үйлчлэхдээ үдийн хоол, цайгаа А байрнаас Б байр руу зөөврөөр олгодог бөгөөд 2 ээлжээр 531 хүүхдийн хоолыг зөөврөөр хүргэж байна. Хоолны цэсийг 5 хоног тутамд БШУЯ-аас гаргасан “ЕБС-ийн үдийн хоолны жор технологи” гарын авлага номын дагуу хүүхдийн хоолны өдөрт авбал зохих илчлэг, шим тэжээлийн хэрэгцээг хангахуйц хоолоор үйлчилж байна. Зориулалтын гал тогоо болон хоол зүйчтэй болох зайлшгүй шаардлагатай байна. | 100% |
| 18 | 10 | АЗДҮАХ-ийн 2.1.5 | Зарим сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж, дотуур байранд их засвар хийх. | Их засвар хийгдсэн сургууль, цэцэрлэгийн тоо | Улсын төсвийн хөрөнгөөр баригдах 320 хүүхдийн суудалтай сургуулийн өргөтгөлийн барилгын ажилд “Асуд констракшн ХХК” шалгарч, ажил | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эхэлсэн байна. 2023 оны Улсын төсөвт 1 тэрбум 930 сая төгрөг батлагдсан. | |
| 19 | 11 | АЗДҮАХ-ийн 2.1.5 | Ерөнхий боловсролын сургуулиудыг эрэгтэй, эмэгтэй технологи, хими, физикийн кабинетийн хэрэглэгдэ-хүүнээр хангах. | Кабинетийн хэрэглэгдэхүүнээр хангагдсан сургуулийн тоо | - | 0% |
| **2.2. Эрүүл мэнд** | | | | | | |
| **Зорилт: Эрүүл мэндийн бодлогыг чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 21 | 1 | АЗДҮАХ-ийн 1.1 | Цар тахлын үеийн бэлэн байдал, эм, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, оношлуур, бамбарын нөөц бүрдүүлэлт, тоног төхөөрөмж, дайчлагдан ажиллах хүний нөөц, хариу арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэх. | Нөөц бүрдүүлэлтийн хувь | Цар тахлын үеийн бэлэн байдлыг хангаж өргөн хэрэглээний эм, тариа болон нэг удаагийн хамгаалах хэрэгслийн, Коронавируст халдвар /Ковид-19/-ын халдвар илрүүлэх оношлуурын 2 сарын нөөцийг бүрдүүлсэн. | 100% |
| 22 | 2 | АЗДҮАХ-ийн 10.1.10 | Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсвийн боломжид үндэслэн төлөвлөн батлуулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, халдвар хамгааллын хэрэгслээр мэргэжлийн байгууллагуудыг хангах. | Техник, тоног төхөөрөмж, халдвар хамгааллын хэрэгслээр хангасан эсэх | | 100% |
| 23 | 3 | АЗДҮАХ-ийн 5.1.15 | Томуу, томуу төст өвчин, улаанбурхан, улаанууд зэрэг амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг | Дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн хувь | 2022 оны байдлаар 10, 11 дүгээр сард сумын хэмжээнд, эрүүл мэндийн төвийн ажилчид болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн, астматай иргэд, ахмад, 2-6 настай хүүхдүүд, нийт 408 иргэнийг томуугийн дархлаажуулалтад хамруулсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хамруулах ажлыг зохион байгуулах. | | | |
| 24 | 4 | АЗДҮАХ-ийн 2.1.2 | Хүн амын дунд эрт илрүүлэг үзлэг, халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх оношилгоо, шинжилгээг тасралтгүй зохион байгуулж эрүүл мэндийг дэмжих тусламж үйлчилгээг үзүүлэх | Үзлэг, оношилгоонд хамрагдсан иргэдийн тоо | Тус сумын эрүүл мэндийн төвд 2022 оны 11 дүгээр сарын байдлаар дараах зорилтод насны иргэдийн эрт илрүүлгийн үзлэгт хамруулсан. Үүнд<br>➢ Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 1410<br>➢ Чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг үзлэгт 1352<br>➢ Элэгний хорт хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт 517<br>➢ Хөх, умайн хүзүүний хорт хавдар эрт илрүүлэх үзлэгт 139<br>➢ 0-17 насны хүүхдийн эрт илрүүлгийн үзлэгт 1736 иргэнийг тус тус хамруулсан. | 70% |
| 26 | 6 | АЗДҮАХ-ийн 1.1 | Шинэ коронавируст халдварын дараах хяналт болон уушигны эмгэг илрүүлэх “Эрүүл амьдралын төлөө хамтдаа” үзлэг оношилгоог бүх сум тосгонд зохион байгуулах. | Үзлэгт хамрагдсан иргэдийн хувь | 2022 онд коронавируст халдварын нийт 98 тохиолдол бүртгэгдсэн.<br>Аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран 9 дүгээр сарын 7,8-ны өдрүүдэд 2 өдрийн хугацаанд шинэ коронавируст халдварын дараах хяналт болон уушгины эмгэг илрүүлэх үзлэгийг зохион байгуулсан. Сүрьеэ өвчний өрхийн болон ойрын хавьтал, зорилтот бүлгийн 150 иргэний судалгааг гаргаж, цээжний рентгенд шинжилгээнд хамруулсан. Үзлэгт зорилтот бүлгийн 208 иргэн хамрагдснаас 9 иргэн өөрчлөлттэй гарч, цэрний шинжилгээнд хамрагдсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 27 | 7 | АЗДҮАХ-ийн 1.3 | Иргэд, олон нийтэд “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг эрчимжүүлэх. | Зохион байгуулсан арга, хэмжээний тоо, -түүнд хамрагсдын тоо | Эрүүл мэндийн төвийн 1 их эмч, Ахлах сувилагч нар “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтад 1 удаа хамрагдсан. Цаг уурын байдалтай холбоотой мэдээлэл, ухуулга, сурталчилгааг эмнэлгийн Selenge Tsagaannuur Emt тогтмол байршуулсан. Энэ оны байдлаар нийт 32 мэдээлэл оруулсан.<br>Эмнэлгийн эмч ажилчдыг коронавирусийн халдвараас сэргийлэх үүднээс витаминжуулах аяныг 1 сар өрнүүлж, 24 ажилтныг хамруулсан. | 70% |
| 28 | 8 | АЗДҮАХ-ийн 2.1.2 | Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, “Эрүүл идэвхтэй амьдрал”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл гэр бүл-Эрхэм баян” арга хэмжээг зохион байгуулах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>-Түүнд хамрагсдын тоо | 2022 оны 11 сарын байдлаар дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.Үүнд: Эрүүл идэвхтэй амьдрал, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”,“Хавдрын эсрэг”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл чийрэг эр хүн”, “Халдварт бус өвчин”, “Халдварт өвчин”, “Орчны эрүүл мэнд болон нийт 11 хөтөлбөрөөр төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд 1 бүсийн хэмжээнд арга хэмжээ явуулж, сургалт, сурталчилгаа 27 удаагаар 857 хүнийг хамруулсан. Гарын авлага сургалтын материал 3256 ширхгийг хэвлэж тараасан. | 100% |
| 29 | 9 | АЗДҮАХ-ийн 2.1.4 | Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах. | -Мэдээллийн цахим сангийн баяжилтийн хувь<br>-Цахим сүлжээний орчин бүрдүүлсэн эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь | Тус эрүүл мэндийн төв энэ онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр авахад бүрэн шилжиж https://e-hospital.mn/ сайтаар бүртгэж байгаа бөгөөд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сувилагч нарыг бүрэн компьютер, интернэтээр хангаж ажилласан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 32 | 12 | Улсын төвийн хөрөнгө оруулалт | Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын их засварын ажил | Их засвар хийгдсэн эсэх | 2022 оны төсөв их засвар төлөвлөгдөөгүй. | |
| 33 | 13 | АЗДҮАХ-ийн 2.1.1 | Эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах. | Тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллагын тоо | 2022 онд "Атартрейд" ХХК, МУ-ын арслан Б.Орхонбаяр нар хамтран сумын Эрүүл мэндийн төвд 23.0 сая төгрөгийн өртөг бүхий шүдний кабинтын иж бүрэн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. | 70% |
| | | | | Ашиглалтад орсон эсэх | Ашиглалтад ороогүй. | |
| 34 | 14 | "Алсын хараа-2050"-ын 2.2.23 ЗГҮАХ-ийн 2.1.9 МУХҮЧ-ийн 2.2.8, ААЗДҮАХ-ийн 2.1.5 | Мэргэжлийн өндөр ур чадвартай, туршлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтны гэрээний тусгай нөхцөлтэйгөөр ажиллуулах, туршлага сущдлуулах, давтан сургах арга хэмжээг үе шаттай зохион байгуулах. | -Гэрээ байгуулсан эмч ажилчдын тоо<br>-Давтан сургалтанд хамрагдсан эмнэлгийн ажилтны тоо | 2022 оны байдлаар шинээр уламжлалын их эмч авсан бөгөөд сурах гэрээг одоогоор 1 тусгай мэргэжилтэн, 2 ажилтан хийсэн. Эмнэлгийн 3 мэргэжилтэнг 100% мэргэжил олгохоор цалинтай сургаж байна. | 100% |
| **2.3. Гэр бүл** | | | | | | |
| **Зорилт: Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүний хөгжлийг дэмжинэ.** | | | | | | |
| 36 | 1 | АЗДҮАХ-ийн 2.5.1 ТЖҮЧ-ийн 2.3.2 | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж **"Хүчирхийлэлгүй аймаг"** болох бодлогыг хэрэгжүүлэх | -Хамрагдсан гэр бүлийн тоо<br>-Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн үйлдлийн тоо | Гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй хүүхдүүдийн 37 эцэг эх, асран хамгаалагчтай нийгмийн ажилтан уулзаж, ярилцлага хийж, ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан. Сумын хамтарсан баг архины хамааралтай, хүчирхийлэлтэй нийт 19 гэр бүлд очиж үйлчилгээ үзүүлсэн.<br>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, энэ талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлын | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд сумын төвийг тойрсон хатуу хучилттай зам дагуу 3 ширхэг нөлөөллийн самбар байрлуулсан. Самбараар дамжуулан гэр бүлийн хүчирхийлийн дуудлага мэдээллийг хүлээн авах утсыг сурталчилсан бөгөөд ингэснээр 108 дугаарын утасны талаарх иргэдийн ойлголт нэмэгдэж хүчирхийлэл үйлдэх гэж байгаа болон үйлдсэн этгээдүүдийг түргэн шуурхай илрүүлэх ажилд иргэдийн оролцоо нэмэгдээд байна. | |
| 37 | 2 | АЗДҮАХ-ийн 2.5.4 ТЖҮЧ-ийн 2.3.3 | Эцэг, эх, асран хамгаалагчдад хүмүүжлийн эерэг арга, хандлагыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг эцэг, эхийн зөвлөлөөр дамжуулан зохион байгуулах. | Сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо | СӨБ-ийн багш нараар дамжуулан “Гар утас тоглоом биш” гарын авлагыг 5 удаагийн үйл ажиллагаагаар 970 эцэг эх, асран хамгаалагчдад, “Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх арга аргачлалыг түгээн дэлгэрүүлэх” сургалт нөлөөллийн ажил, “Цахим хэрэгсэлд донтох, донтолтын хор нөлөө” сэдвээр сургалт, мэтгэлцээн, “Дэлгэцийн донтолт ба гэр бүлийн анхаарал “ сэдвийн хүрээнд багш эцэг эхийн хамтарсан 2 баг хүүхдүүдэд жүжигчилсэн тоглолт, “Дэлгэцтэй биш, дэлгэсэн номтой нөхөрлөе” цуврал сургалт, “Гар утас хүүхэд аргадах тоглоом биш” сэдэвт сургалт, “Дэлгэцийн донтолтоос сэргийлж эрүүл мэндээ хамгаалцгаая” аяны хүрээнд “Спортлог гэр” бүл өдөрлөг зэргийг зохион байгууллаа. сургалтуудад давхардсан тоогоор 1100 эцэг эх, асран хамгаалагчид, сурагчид, сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг хамруулсан.<br>Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс долоо хоногийн бямба гараг бүр ” Гэр бүлээрээ утасгүй цаг “ нөлөөллийн арга хэмжээг өрнүүлж “ Миний гэр бүлийн аз жаргал “ сэдэвт үйл ажиллагааг зохион явуулсан нь ихээхэн үр дүнтэй болсон. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хамтарсан багийн үүрэг чиглэлийн дагуу 2 дугаар цэцэрлэгийн багш зорилтот өрхийн хүүхдийн 1 удаа гэрээр эргэлт хийж, хүүхдийн хөгжилд гэр бүлийн оролцоо, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар яриа таниулгыг 72 эцэг эх, асран хамгаалагч нарт хийсэн. | |
| 38 | 3 | АЗДҮАХ-ийн 2.5.3, 2.5.4 ТЖҮЧ-ийн 2.3.4 | Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах. | -Тохиолдлын шийдвэрлэлтийн хувь<br>-Хамтран ажилласан байгууллага | Аймгийн Гэр бүлийн газрын ажилтан болон цагдаагийн газрын алба хаагч нартай хамтран 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, мэдээлэл солилцон хамтран ажилласан. Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор аймгийн ГБХЗХГ-аас зохион байгуулагдсан НАМС-ын сургалт, НБХМэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, “Хүүхэд хамгааллын кейс менежмент”, “НАМС-ыг ашиглах нь”зэрэг сургалтуудад хамрагдсан.<br>Хамтарсан багийн үйл ажиллагааг сурталчлах, хамтран ажиллахад хүн бүрийн оролцоо маш чухал гэдгийг сурталчлах зорилгоор сургуулийн багш ажиллагсдад “Хүүхэд хамгаалал-Хамтарсан баг” сургалтыг зохион байгуулсан.<br>Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж сумын хамтарсан баг сумын хэмжээнд хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой нийт 21 кейсийг шийдвэрлэж ажилласан.<br>Архины хамааралтай 2 иргэнийг архинаас гаргах эмчилгээнд хамруулсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 40 | 5 | АЗДҮАХ-ийн 2.5.2, 2.5.4 ТЖҮЧ-ийн 2.3.6, 2.3.7 | Хүүхэд бүрийг хөгжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах. | Хамрагдалтын хувь | “Хүүхдээ сонсоцгооё” нээлттэй форм сумын Ерөнхий боловсролын сургуулийн 10-р ангийн 4 сурагч, ахмад багш нарын төлөөлөл 8 багш, 52 хүүхдэд зохион явууллаа.<br>2022 оны 11 дүгээр сарын байдлаар сумын хэмжээнд 37 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Уг хүүхдүүдэд ЕБС болон СӨБ олгох үйл ажиллагааг тэгш хүртээмжтэй чанартай хүргэх, тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийг хамруулах үүднээс судалгаа гаргахад СӨБ-д 6 хүүхэд, ЕБС-д 13 хүүхэд боловсролын үйлчилгээ авч байна. Эдгээр хүүхдүүдээс 1 хүүхэд эцэг эхийн хүсэлтээр цахимаар СӨБ-д хамрагдаж байна. Эдгээр хүүхдийн суралцах үйлийн онцлогт тохируулан дасгал даалгавар, ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. 18 хүүхэд нь СӨБ-өөс өмнөх насны болон суралцах бэрхшээлтэй хүүхэд байна. Эдгээр хүүхдүүдээс 1 хүүхэд эцэг эхийн хүсэлтээр цахимаар СӨБ-д хамрагдаж байна. Эдгээр хүүхдийн суралцах үйлийн онцлогт тохируулан дасгал даалгавар, ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. | 100% |
| 41 | 6 | АЗДҮАХ-ийн 2.5.7 ТЖҮЧ-ийн 2.3.6 | Жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх. | Сургалт, нөлөөллийн ажлын тоо<br>Хамрагдсан иргэдийн тоо | Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилчдын дунд Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/625 “Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар бодлого батлах тухай” бодлогоор 1 удаа дотоодын сургалт хийж 24 эмч, ажилчдыг хамруулсан. | 30% |
| **2.5.Хүн ээлтэй амьдрах орчин** | | | | | | |
| **Зорилт: Эрүүл баталгаат орчныг бүрдүүлэх.** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 44 | 1 | САХТЖҮЧ-ийн 2.5.1 | Хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, гарал үүсэл, хадгалалт, тээвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх. | -Үйлдвэрлэсэн мах, сүүний хэмжээ | Мал эмнэлгийн нэгдсэн системд амьд мал, амьтан 10917 толгой, мах 297767кг, сүү 9960л, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн цувдай 19872кг, толгой 3181ш, ааруц 85кг, ааруул 52кг, шар тос 10кг, өрөм 10кг, арьс шир 2856ш тус тус 2085 ширхэг мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт тавьж баталгаажуулсан. | 50% |
| 45 | 2 | САХТҮЧ-ийн 2.5.2 | Орон сууц, нийтийн эзэмшлийн талбайн ногоон байгууламжийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэх. | -Ногоон байгууламжийн хэмжээ /м2/ | Аймгийн Засаг даргын ”Бүх нийтээр мод тарих арга хэмжээ зохион байгуулах” ажлын хүрээнд 5,10 дугаар сард “ТЭРБУМ МОД-ЦАГААННУУР СУМ 2022” зөвлөгөөнийг сум дундын ойн ангитай хамтран зохион байгуулж Шаамар сумын мод үржүүлгийн газруудтай хамтран тарьц суулгацын үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Нийтийн эдэлбэр газарт шинээр 6 ширхэг бичил цэцэрлэг 3 га-д байгуулсан. Үүнд нарс 258 ширхэг, гоёлын мод 360 ширхэг, иргэд гоёлын мод 21 ширхэг, жимсний мод 69 ширхгийг, ААНБайгууллага гоёлын мод 82 ширхэг, жимсний мод 184 ширхгийг тус тус тарьсан байна. Сумын хэмжээнд нийт шилмүүст мод 258 ширхэг, гоёлын мод 381 ширхэг, жимсний мод 253 буюу нийт 892 ширхгийг тарьсан. | 100% |
| 46 | 3 | САХТЖҮЧ-ийн 2.5.5 | Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх. | -Бүртгэл хяналтын тоо | Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор ажлын хэсэг гарч 3 удаагийн хяналт шалгалтыг хийсэн. Нийт давхардсан тоогоор 22 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан. Шалгалтаар 74 нэр төрлийн /2сая 300мянга/ төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн лангуунаас татуулан буцаалт хийлгүүлж, 120 гаруй нэр төрлийн /1 сая 970 мян/ төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг байгууллагын | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дотоод хяналтын журмын дагуу устгуулж ажилласан. Шалгалтаар 194 зөрчил илрүүлэн 180 буюу 92.7 хувийг арилгасан. Илэрсэн зөрчлийн 40 хувь нь шошгын мэдээллийг бүрэн тусгаагүй, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдсан, гарал үүсэл нь тодорхойгүй, хадгалалтын горим алдагдсан, хугацаа дууссан зэрэг зөрчлүүд илэрч байна.Хяналт шалгалтын ажлыг тогтмол хийж хэвшээд байна. | |
| **2.6. Хөдөлмөрийн зах зээл** | | | | | | |
| **Зорилт**: **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, орлого олох боломжийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 47 | 1 | “Алсын хараа-2050”-ийн 2.6.2, МУХҮЧ-ийн 2.6.2 ЗГҮАХ-ийн 2.5.9 | Хөгжлийн бэрхшээлтэй болон ажилгүй залуучуудыг аж ахуй эрхлэх болон ур чадвар олгох сургалтанд хамруулах. | -сургалтын тоо<br>-Хамрагсадын тоо | “Аж ахуй эрхлэх” сургалтад 4 залуу малчинг оролцуулж, 3 малчин өрх нь 2021, 2022 малжуулах төсөл хөтөлбөрт хамрагдсан 1 малчин өрх нь ХБИргэний төсөл хөтөлбөрт хамрагдсан. | 70% |
| 48 | 2 | “Алсын хараа-2050”-ийн 2.6.3, МУХҮЧ-ийн 2.6.2 | Ажлын байр олноор бий болгож байгаа болон ажлын байраа хадгалж байгаа аж ахуй нэгж, байгууллагад бодлогын дэмжлэг үзүүлэх. | Урамшуулалд хамрагдсан аж ахуй нэгж, байгууллагын тоо | Одоогоор материал ирүүлсэн ААНБ байхгүй байна. | 0% |
| 49 | 3 | “Алсын хараа-2050”-ийн 2.6.4, МУХҮЧ-ийн 2.6.4 | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулж, мэдээллийн санг өргөжүүлэх. | Мэдээллийн сангийн баяжилтын хувь | Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийн LMIS программ ашиглаж байна. Мөн IJob программыг ашиглалтад оруулахаар мэргэжилтнүүд сургалтад хамрагдсан. | 30% |
| 50 | 4 | “Алсын хараа-2050”-ийн 2.6.8, | Ажил олгогчийн захиалгыг үндэслэн хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэр эрхлэх | -сургалтын тоо<br>-Хамрагсадын тоо | Ажил олгогчоос одоогоор ямар нэгэн санал ирээгүй байна. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | МУХҮЧ-ийн 2.6.2 | мэргэжилтэн бэлтгэх, ажлыг зохион байгуулах. | | | |
| 51 | 5 | МУХҮЧ-ийн 2.6.1 | Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангуулах, ажилтан, ажил олгогчийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд хяналт тавих, зөвлөн туслах. | Зохион байгуулсан арга хэмжээ 5 Хамрагдсан аж ахуй нэгжийн тоо | Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдүүлэх зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр ажлын хэсэг байгуулагдаж 10 байгууллагын үйл ажиллагаанд зөвлөх туслах, хянан шалгах ажлын зохион байгуулсан.<br>2022 онд Сумын ХАБЭА-н зөвлөлийг шинэчилэн байгуулсан.<br>2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 31-ний өдөр хүртэл олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. Захирамж, төлөвлөгөө боловсруулсны дагуу ахуй үйчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, иргэдэд худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдлын газраас гаргасан зөвлөмж, гарын авлага мэдээллийг хүргэсэн. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмжийг цахимаар болон мэдээллийн самбар сурталчлан ажилласан. | 100% |
| 52 | 6 | ЗГҮАХ-2.5.10, МУЖХХОТ-2.5.9 | Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагуудад цахим мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх. | Цахимд бүрэн шилжсэн сургуулийн тоо | - | |
| **2.7.Монгол хүний удмын сан** | | | | | | |
| **Зорилт: Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ.** | | | | | | |
| 53 | 1 | МУТЖҮЧ-ийн 2.7, САХТЖҮЧ- | “Ураг удмын Алтан хэлхээ” угийн бичгийн бүсчилсэн сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах. | Угийн бичиг хөтөлдөг өрхийн нийт өрхөд эзлэх | "Ургийн бичиг" хөтлөхийн ач холбогдлын талаар Тийрэг 3-р баг,Оргих-1р багийн малчид, сумын иргэддээ мэдээлэл өгч угийн бичиг хөтлөх | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ийн 1.1.1 | | хувь | аргачлал номыг танилцуулан 65 иргэнд өгсөн. Гэрийн угийн бичиг түүнийг хэрхэн зөн хөтлөх арга зүйн тухай цуврал 3 видео бичлэгийг “Цагааннуур Соёлын төв” цахим хуудсанд байршуулан танилцуулсан. Зүүнбүрэн суманд 2022 оны 5 сард аймгийн номын сангаас “Угийн бичиг”-ийг хөтлөх сургалт явуулж Сэлэнгэ бүсийн номын санчид хамрагдсан | |
| 54 | 2 | “Алсын хараа-2050” 2.7.2, МУХҮЧ-ийн 2.7.2 | Оюун ухааны хомсдол болон сэтгэц мэдрэлийн өвчнөөс урьдчилан эрт оношлох, сэргийлэх. | Үзлэг, шинжилгээнд хамрагдсан иргэдийн хувь | Оюун ухааны хомсдол болон сэтгэц мэдрэлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор СӨБ-ийн багш нараар дамжуулан “Гар утас тоглоом биш” гарын авлагыг 5 удаагийн үйл ажиллагаагаар 970 эцэг эх, асран хамгаалагчдад, “Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх арга аргачлалыг түгээн дэлгэрүүлэх” сургалт нөлөөллийн ажил, “Цахим хэрэгсэлд донтох, донтолтын хор нөлөө” сэдвээр сургалт, мэтгэлцээн, “Дэлгэцийн донтолт ба гэр бүлийн анхаарал “ сэдвийн хүрээнд багш эцэг эхийн хамтарсан 2 баг хүүхдүүдэд жүжигчилсэн тоглолт, “Дэлгэцтэй биш, дэлгэсэн номтой нөхөрлөе” цуврал сургалт, “Гар утас хүүхэд аргадах тоглоом биш” сэдэвт сургалт, “Дэлгэцийн донтолтоос сэргийлж эрүүл мэндээ хамгаалцгаая” аяны хүрээнд “Спортлог гэр” бүл өдөрлөг зэргийг зохион байгууллаа. сургалтуудад давхардсан тоогоор 1100 эцэг эх, асран хамгаалагчид, сурагчид, сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг хамруулсан.<br>Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс долоо хоногийн бямба гараг бүр ” Гэр бүлээрээ утасгүй | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цаг " нөлөөллийн арга хэмжээг өрнүүлж " Миний гэр бүлийн аз жаргал " сэдэвт үйл ажиллагааг зохион явуулсан нь ихээхэн үр дүнтэй болсон. | |
| 55 | 3 | Алсын хараа 2050-ын 2.7.2 | Цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийг эрт оношлох. | Удамшлын өвчнийг эрт оношилсон эсэх | - | |
| **ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА** | | | | | | |
| **Зорилго:Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.** | | | | | | |
| **3.1. Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл** | | | | | | |
| **Зорилт:Нийгмийн хамгааллын шинэчлэлд иргэн бүрээ хамруулна.** | | | | | | |
| 56 | 1 | "Алсын хараа-2050" 3.1.12, ЗГҮАХ-ийн 2.5.6, МУХҮЧ-ийн 3.1.3 | "Ковид-19" цар тахлын үед нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах. | E-mongolia холбогдсон эсэх, үйлчилгээ авсан иргэдийн тоо | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-mongolia цахим системээр нийт 271 төрийн үйлчилгээг иргэдэд олгож байна. 2022 оны 11-р сарын байдлаар оператороор дамжуулан 202, гар утасны апплекейшнаар зөвлөгөө мэдээлэл, туслалцааг 184 иргэнд үзүүлсэн. | 100% |
| 57 | 2 | "Алсын хараа-2050" 3.1.25, ЗГҮАХ-ийн 2.5.7, МУХҮЧ-ийн 3.1.3 | Зорилтот бүлгийн өрхүүдэд амьжиргааг дэмжих төслийг хэрэгжүүлэх. | Төсөлд хамрагдсан иргэдийн тоо | 2022 онд ОНОТХҮ хамрагдахаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэрээрээ асардаг 1 иргэн "Боломж" оёдолын төслөөр 2 сая төгрөг авч оёдолын машин, материал худалдан авч ажиллан өөрөөсөө гадна нэг ажлын байр бий болгоод байна. Цаашид уг төсөлд хамрагдсанаар хүүхдээ хараад хажуугаар нь гэрээсээ орлого олох бүрэн боломжтой болоод байна. | 50% |
| 58 | 3 | "Алсын хараа-2050" 3.1.26, ЗГҮАХ-ийн 2.5.8, МУХҮЧ-ийн | Ахмад настнуудад зориулсан үйлчилгээг өргөжүүлэх. | Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо | Ахмад настанд хөнгөлөлтөд 22 иргэн, алдар цолтон ахмад настанд олгох хөнгөлөлтөд 7 иргэн, хүндэт донорт олгох хөнгөлөлтөд 1 иргэн, байгууллагын харъяалалгүй ахмад настанд олгох тэтгэмжид 10-аас доошгүй иргэн, насны хишиг тэтгэмжид 170 иргэн, нийт 210 ахмад настан | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3.1.3 | | | хамрагдаад байна. Мөн Ахмадын ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд 1 ахмад иргэнд “Төмөр хийц” төслөөр 5 сая төгрөгийг 24 сарын хугацаатай олгосон.<br>Сумын ахмадууд ахмадын хорооны байрандаа хөдөлгөөн дасгал тогтмол хийж, уламжлалт шагайн наадгай, шатар гэх мэт оюуны спортоор хичээллэн чөлөөт цагаа өнгөрөөж байна. Ахмадуудын чөлөөт цагаа ахмадын байрандаа ая тухтай өнгөрөөхөд нь дэмжлэг болгож сумын Засаг даргаас 1 сая төгрөгийн үнэ бүхий хөргөгчийг худалдан авч бэлэглэлээ. | |
| 59 | 4 | “Алсын хараа-2050” 3.1.11, САХТЖҮЧ-ийн 3.1.2, АЗДҮХ-ийн 2.6.18 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон хураамжийн төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх. | Хяналт тавьсан эрүүл мэндийн байгууллагын тоо | - | |
| 60 | 5 | “Алсын хараа-2050” 3.1.11, САХТЖҮЧ-ийн 3.1.2, АЗДҮХ-ийн 2.6.18 | Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлж буй эмийн сангуудын жороор олгосон эмийн үнийг хяналтыг хэрэгжүүлэх. | Чанарын шалгалтад хамрагдсан байгууллагын тоо | Эрүүл мэндийн даатгалын сангаас 1717 даатгулагчдад Урианхай шүрэн Уул ХХК-тай хамтран хөнгөлөлттэй эмийн жороор үйлчилсэн. | 100% |
| 61 | 6 | “Алсын хараа-2050” 3.1.1 | Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх. | Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагсадын тоо | Сайн дурын даатгалд хамрагдсан даатгуулагч оюутан 4 ажил хөдөлмөр эрхлээгүй 15 Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчин иргэн 51 иргэнийг сайн дурын даатгал, 428 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулсан. | 100% |
| 62 | 7 | “Алсын | Нийгмийн даатгалын цахимаар | Цахимаар үзүүлэх | Нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод түргэн | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хараа-2050” 3.1.3 | үзүүлэх үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх. | үйлчилгээний төрлийн тоо | шуурхай хүргэж байна.Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн оператор болон e-mongolia болон нийгмийн даатгалын апплекейшн ашиглан иргэд болон аж ахуйн нэгж байгууллагууд гар утаснаасаа нийгмийн даатгалын лавлагаа, тодорхойлолт авах боломжтой болсон. 2022 онд “E.Mongolia” “https://daatguulagch.ndaatgal.mn/” даатгуулагчид зориулсан вэб сайт болон нийгмийн даатгалын гар утасны “ndaatgal.mn” аппилкэйшн ашиглан даатгуулагчид үйлчилж байна. Мөн хөдөлмөрийн чадвараа түр алдсан тэтгэмж, Жирэмсэн амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж бүрэн цахимжиж, нийгмийн даатгалын 50 хувийн буцаан олголттой холбогдуулан данс холбох засах үйлчилгээг нэмэгдүүлэн ажил олгогч, иргэд цахимаар авах бүрэн боломжийг ханган ажилласан. E-mongolia системээс даатгуулагч 11 төрлийн үйлчилгээг бүрэн авах боломж бүрдсэн байна. | |
| **3.2.Орлогод нийцсэн орон байр** | | | | | | |
| **Зорилт: Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт ницсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.** | | | | | | |
| 63 | 1 | САХТЖҮЧ-ийн 3.2.1 | Орон сууц барих аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | Орон сууцжуулсан өрхийн тоо, хамрагдалтын хувь | Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор Эрүүл мэндийн төвийн ажиллагсадын байрны суурь тавигдан баригдаж байгаа бөгөөд “Төрийн орон сууц” корпорацтай хамтран 2 өрөө байрыг гэрээний дагуу худалдан авч шинээр суманд ирж ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг түр суулгаж байна.<br>Шинэбадрах ХХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд хувийн орон сууц барих, ажлын байр бий болгох сумын ЖДҮ эрхлэгч 3 иргэнд цэвэр банз 15*15 харьцаатай палк нийт 374.5м3 мод, модон материалыг хөнгөлөлттэй үнээр олгож | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. | |
| 64 | 2 | САХТЖҮЧ-ийн 3.2.2 | “Амины орон сууц” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Шинээр баригдсан амины орон сууцны тоо | Хэрэгжээгүй | |
| **3.3. Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес** | | | | | | |
| **Зорилт: Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.** | | | | | | |
| 65 | 1 | “Алсын хараа-2050” 2.3.7, 3.3.1, 3.3.15 ЗГҮА-ийн 2.5.14 МУХҮЧ-ийн 3.3.1 | Залуучуудад бизнес эрхлэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх. | Үйлчилгээний төрлийн тоо | Хэрэгжээгүй | 0% |
| 66 | 2 | “Алсын хараа-2050” 2.3.7, 3.3.1, 3.3.15 ЗГҮА-ийн 2.5.14 МУХҮЧ-ийн 3.3.2 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжиж ажиллах. | Дэмжлэг үзүүлсэн иргэний тоо | 2022 онд шинээр “Баялаг ундраа” хэрчсэн гурилын цех, “Очир” талх, хэрчсэн гурилын цехүүд ашиглалтад орсон. Холбогдох бичиг баримтын бүрдлийг хянан зөвшөөрлийг өгсөн. Үүнд: Ажлын байрны эрүүл ахуй, стандартын шаардлагыг хагуулах, хүнсний аюулгүй байдал, дүрэм, журам холбогдох стандартыг хэрэгжүүлж зөвлөгөө, мэдээллээр ханган хяналт тавин ажилласан. | 30% |
| 67 | 3 | “Алсын хараа-2050” 2.3.7, 3.3.1, 3.3.15 ЗГҮА-ийн 2.5.14 МУХҮЧ-ийн 3.3.3 | Малчид хүнсний ногоо тариалагчдыг хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дэмжиж ажиллах. | Дэмжлэг үзүүлсэн иргэний тоо | Ногоочдод хүнсний ногоо тариалахад туслах тоног төхөөрөмжийн дундын парк бий болгох ажлыг аж ахуйн нэгж байгууллагатай хамтран шийдвэрлэнэ. | 0% |
| **3.4. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт: Ард иргэд, хүүхэд залуучуудаа бялдаржуулан чийрэгжүүлж, эрүүлжүүлэх зорилт хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 68 | 1 | “Алсын хараа-2050” 3.3.4 ЗГҮА-ийн 2.2.1 МУХҮЧ-ийн 3.5.3 АЗДҮХ-ийн 2.3.1 | Нийтийн биеийн тамирыг иргэдийн эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлэх | Хичээллэгсдийн тоо | Илүүдэл жингүй –Эртэч Монгол аяны хүрээнд дасгал хөдөлгөөн,эрүүл амьдралын хэв маяг, алхалт хийж нийт 1276 иргэд хамрагдаж, спорт цогцолборт секц дугуйлан 6 төрлөөр хичээллэж 120 гаруй хүүхдүүд хамрагдсан. | 100% |
| 69 | 2 | АЗДҮАХ-ийн 2.3.10 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон төрөлт тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулах. | Зохион байгуулсан тэмцээний тоо, хамрагсадын тоо | Зорилтот бүлгийн иргэдийн дунд 100 буудалт даам, дартс,суугаа волейбол гэсэн 3 төрлийн тэмцээнийг зохион байгуулж нйит 70 гаруй иргэд хамрагдсан. | |
| 70 | 3 | “Алсын хараа-2050” 3.5.12, ЗГҮАХ-ийн 2.2.2, МУХҮЧ-ийн 35.4, АЗДҮХ-ийн 2.3.4 | Өвлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилтыг ахиулахад дэмжлэг үзүүлэх. | Зохион байгуулсан тэмцээний тоо, хамрагсадын тоо | - | |
| 71 | 4 | “Алсын хараа-2050” 3.5.12, АЗДҮХ-ийн 2.3.4 | Бүх сумд байгууллагыг орон тооны бус биеийн тамирын арга зүйчтэй болгох. | Хүний нөөц хангагдсан сумын тоо | Арга зүйчтэй болсон. | 100% |
| 72 | 5 | “Алсын хараа-2050” 3.5.12, АЗДҮХ-ийн 2.3.7 | Иргэд, хүүхэд залуучуудад үйлчлэх, спортын зориулалтын орчин нөхцөлийг сайжруулах. | Ашиглалтад авсан барилгын тоо | Спорт цогцолборын их засварын ажил хийгдэж хүлээлгэн өгсөн. Уг ажлаар бэлтгэлийн өрөө, фитнес, үүдний танхим, бие засах өрөө, албан хаагчдын өрөө, теннисний танхим зэргийг бүрэн засварлаж орчин нөхцөлийг сайжруулсан. | 100% |
| **3.5. Газрын харилцаа** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт: Монгол Улсын газрын харилцаа, геодизи, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 75 | 3 | САХТЖҮЧ-ийн 3.5.5 | Барилга байгууламжийг паспортжуулах орон тооны бус зөвлөл байгуулж, паспортжуулах ажлыг эхлүүлэх. | Паспортжуулсан барилга байгууламжийн тоо | Хувийн хэвшлийн болон төр төсвийн 10 байгууллагын барилга байгууламжийг паспортжуулсан. | 70% |
| 78 | 6 | АИТХ-ын санал | Сумдын хилийн цэсийн асуудлыг шат, шатны байгууллагад уламжилж, хот төлөвлөлтийн өргөжин тэлэх боломжийг эхлүүлэх. | Асуудал шийдвэрлэгдсэн эсэх | Сумын Тийрэг 3 дугаар багийн иргэдийн зуслан Моностой, Гурт, Улаалзганат гэх газруудын Түшиг сумтай хиллэх хилийн маргааныг Сэлэнгэ аймгийн газрын албаныхантай хамтран эцэслэн шийдвэрлэж тэмдэгжүүлсэн. | 100% |
| **ДӨРӨВ. “ЭДИЙН ЗАСАГ”** | | | | | | |
| **Зорилго: Төсвийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан ил тод нээлттэй төлөвлөн хуваарилж, салбарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөв, санхүүгийн менежментийг сайжруулж, аймгийн эдийн засгийг жил бүр тогтвортой өсгөх бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| **4.1. Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд** | | | | | | |
| **Зорилт:Эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлал, үйлвэрлэлийн салбарт түшиглэсэн эдийн засгийн цогцолбор бүс нутаг болно.** | | | | | | |
| 79 | 1 | ХОХБТХ-ийн санал | Орон нутгийн хөгжлийн индексийг батлагдсан аргачлалын дагуу боловсруулж, сумдын түвшинг тодорхойлох. | Орон нутгийн хөгжлийн индексийн үзүүлэлт | - | |
| **4.2. Ухаалаг санхүүгийн бодлого** | | | | | | |
| **Зорилт: Эдийн засгийн тогтвортой өсөлт өрх бүрдээ хүрсэн, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлалын салбарт түшиглэсэн эдийн засгийн цогцолбор бүс нутаг болно** | | | | | | |
| 82 | 1 | АЗДҮАХ-ийн 3.6.1 | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж, төсвийн байгууллагуудын шилэн дансны мэдээллийн хугацаанд нь байршуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах. | Шилэн дансны мэдээллийн байршуулалтын хувь | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган шуурхай удирдлагаар ханган шилэн дансны нэгдсэн сайтад /shilendans.gov.mn/ мэдээллийг үнэн зөв бодитой тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэхийг байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт тухай бүр сануулж төлөвлөгөөний дагуу төсөвт байгууллагуудад 1, 2, 3-р улирлын хяналт шалгалтыг хийж гарсан | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | алдаа дутагдлыг арилгах цаашид давтан гаргахгүй байх үүрэг чиглэл өгч ажилласан. 11 дүгээр сарын байдлаар ТТЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | |
| 83 | 2 | АЗДҮАХ-ийн 3.6.6 | Хөрөнгийн зах зээл форекс арилжааны тухай ойлголт, хэрэглээ болон блокчейн технологид суурилсан биткойны талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах. | Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо | - | |
| 84 | 3 | АЗДҮАХ-ийн 3.6.5 | Шинээр томилогдсон багийн Засаг дарга нар болон сумдын Статистик хариуцсан ажилтнуудыг чадавхижуулах сургалт зохион байгуулах. | Сургалтад хамрагдсан хүний тоо | Аймгийн засаг дарга болон Статистикийн хэлтсээс зохион байгуулсан шинээр томилогдсон багийн Засаг дарга нар болон сумдын Статистик хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах сургалтад 3 багийн засаг дарга, статистик хариуцсан мэргэжилтэнгүүдийг 10 дугаар сарын 27-ны өдөр бүрэн хамруулсан. | 100% |
| 100 %85 | 4 | САХТЖҮЧ-ийн 4.2.1 | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагын татварын баазын бүртгэлийг сайжруулж аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг бүрэн төвлөрүүлж, аймгийн төсвийн орлогын биелэлтийг хангах. | Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь | Татварын орлогын төлөвлөгөө 1,285,963.1 мянган төгрөг төвлөрхөөс 1,577,691.1 мянган төгрөг буюу 122.7 хувьтай биелсэн. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **4.3. Өрсөлдөх чадвартай Брэнд бүтээгдэхүүн** | | | | | | |
| **Зорилт: Сум бүр үйлдвэрлэгч байж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 86 | 1 | АЗДҮАХ-ийн 3.4.7 | “Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Хэрэгжилтийн хувь | Сумын хэмжээнд ахуйн үйлчилгээний чиглэлээр нийт 19 иргэн, ААН үйл ажиллагаа эрхэлж байна. 2022 онд засварын иж бүрэн тоног төхөөрөмжтэй авто засварын газар ашиглалтад орсон бөгөөд ОНХС-ын хөрөнгө оруулалтаар нийтийн боловсон 00 барих ажил 50 хувьтай явагдаж байна. Ахуй үйлчилгээний чиглэлээр явуулж буй иргэдийн ажлын байранд жилд 2 удаа хяналт шалгалтыг зохион байгуулж заавар, зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан | 50% |
| 87 | 2 | САХТЖҮЧ-ийн 4.3.1 | “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг зохион байгуулах. | Шийдвэрлэлтийн хувь | 2022 онд Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын дагуу 6 аж ахуй нэгжийн зөвшөөрлийг сунгасан. Урьдчилан сэргийлэх 3 удаагийн хяналт шалгалтаар тусгай зөвшөөрөлтэй 11 аж ахуй нэгж хамрагдсан. | |
| 88 | 3 | САХТЖҮЧ-ийн 4.3.5 | “Сэлэнгэд үйлдвэрлэв”, “Сэлэнгэ ургац”, “Гонгорын бумбаны тахилга”, “Цам харайх”, “Майдар эргэх”, “Монос цэцэглэх үеэр”, “Хараагийн баяр” арга хэмжээнүүдийг зохион байгуулах. | Оролцсон аж ахуйн нэгжийн тоо, борлуулалтын дүн | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний нээлтийн хүрээнд “Сэлэнгэ Алтан намар 2022” нэгдсэн арга хэмжээ 10 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд сумын жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэгч 6 иргэн 5 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 3 сая гаран төгрөгний орлого олж, сумын 1 иргэн сүү, цагаан идээний бэлгийн багц бүтээгдэхүүнээрээ шагнал хүртэж амжилттай оролцсон. | 100% |
| 89 | 4 | Бодлогын хэлтсийн санал | Орчин үеийн шийдэл бүхий худалдаа үйлчилгээний төвийг ашиглалтад оруулах. | Худалдаа үйлчилгээний төвийг байгуулсан эсэх | 2022 онд шинээр ашиглалтад орсон худалдаа үйлчилгээний газар байхгүй. | 0% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 90 | 5 | Бодлогын хэлтсийн санал | “Сумдын онцлох брэнд бүтээгдэхүүнээр бэлгийн багц гаргах ажлыг зохион байгуулах. | Бэлгийн багцтай болсон эсэх | “Сэлэнгэ Алтан намар -2022” нэгдсэн арга хэмжээнд сумын 1 иргэн сүү, цагаан идээний бэлгийн багц бүтээгдэхүүнээрээ шагнал хүртсэн. | 50% |
| **ТАВ. ЗАСАГЛАЛ** | | | | | | |
| **Зорилго: Нутгийн захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн албыг бэхжүүлж, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээг төлөвшүүлэн, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлийг бүх талаар дэмжсэн хүний эрхийг дээдэлсэн авлигагүй, ХАРИУЦЛАГАТАЙ, ТЭГШ, НЭЭЛТТЭЙ төрийн үйлчилгээ бүхий аймаг байна.** | | | | | | |
| **5.1. Ухаалаг бүтэц** | | | | | | |
| **Зорилт: Нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдо, хувийн хэвшүилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | |
| 91 | 1 | САХТЖҮЧ-ийн 5.1.1 | Нутгийн захиргааны байгууллагуудад чиг үүргийн шинжилгээ хийж ажил, үүргийн давхцлыг арилгах | Давхцсан чиг үүргийн тоо | Сумын ЗДТГ нь батлагдсан орон тооны дагуу албан тушаалын шинэчилсэн тодорхойлолтыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | 100% |
| 92 | 2 | АЗДҮАХ-ийн 4.1.2 | Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирил болон үндэсний бичгээр хослуулан явуулах ажлыг эхлүүлж бүх шатны байгууллагуудад сургалт зохион байгуулах | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | “Үндэсний бичиг соёлын өдөр” хүрээнд Үндэсний бичгээр унших, бичих арга барилыг бий болгох 5 удаагийн уралдаант тэмцээнд 54 төрийн албан хаагчийг хамруулсан. | 30% |
| 93 | 3 | АЗДҮАХ-ийн 4.1.5 | Иргэдийн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх зарчмыг баримтлан “ТАНЫГ СОНСЪЁ” арга хэмжээг “Төлөөлөгчдийн өдөр”-тэй хамтатган зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 дугаар улирлын байдлаар сумын төр, төсвийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс 36 өргөдөл гомдол ирүүлсэн бөгөөд 100% хувь хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн.<br>2021 оны ажлын үр дүнг тайлагнах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх зорилгоор 02 дугаар сард сумын ИТХ-ын төлөөлөгчид, ЗДТГ, ЭМТ-ийн ажилтнууд хамтран 8 хэсэг болж 1, 3 дугаар багийн 380 малчин өрхөөр явж өвөлжилт хаваржилтын байдалтай танилцан, сумын ЗДТГ-аас 2021 онд зохион байгуулсан ажлын тайлан болон цаг үеийн ажлын мэдээлэл хүргэж ажиллалаа. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сумын Засаг дарга 1 дугаар улиралд 1, 2, 3 дугаар БИНХ-аар, 2 дугаар улиралд төр төсвийн байгууллагуудын албан хаагчидтай, 3 дугаар улиралд 2,3 дугаар багийн өдөрлөгөөр малчид иргэдтэй уулзалт зохион байгуулж ажиллалаа. | |
| 94 | 4 | АЗДҮАХ-ийн 4.1.6 | Гадаад харилцаа хамтын ажиллагааны шинэ түншлэлийг нэмэгдүүлэх. | Шинэ түншлэлийн тоо | - | |
| **5.2. Цахим засаглал** | | | | | | |
| **Зорилт: Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг үе шаттай хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 95 | 1 | АЗДҮАХ-ийн 4.1.4 | Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем ERP-E-Mongolia.mn цогц системийг аймгийн хэмжээнд нэвтрүүлэх | Нэвтрүүлсэн байгууллагын тоо | ERP Mongolia.mn цахим системийг Аймгийн хэмжээнд нэвтрүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулсан сургалтад төр, төсвийн 7 байгууллагын архив, бичиг хэргийн ажилтануудыг хамруулсан. | 70% |
| 96 | 2 | САХТЖҮЧ-ийн 5.2.2 | E-Mongolia цахим үйлчилгээний талаар сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд цахим үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх. | Цахим үйлчилгээ авсан иргэдийн тоо | E-mongolia цахим үйлчилгээний талаар сумын веб сайт болон цахим хаягаар дамжуулан сурталчилан ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар оператороор дамжуулан 154, гар утасны апплекейшнаар зөвлөгөө мэдээлэл, туслалцааг 184 иргэнд үзүүлсэн. | |
| **5.3. Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба** | | | | | | |
| **Зорилт: Иргэд үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, чадахуйн зарчимд тулгуурласан ухаалаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ.** | | | | | | |
| 97 | 1 | АЗДҮАХ-ийн 4.1.13 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг зохион байгуулж зөвлөн туслах үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлэх. | Зөрчлийн тоо | 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Сумын Засаг даргын А/37 тоот “Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай” захирамжийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 24-нөөс 26-ны өдрүүдэд “Хоггүй цэвэрхэн-Цагааннуур” аяныг өрнүүлж 160 гаран иргэнийг хамруулан ойр орчмынхоо 50м болон сумын төв доторх 1,3 км засмал замыг цэвэрлэж нийт 4 тн хогийг хогийн нэгдсэн цэгт буулгасан. Сумын хэмжээнд “Бүх нийтийн | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цэвэрлэгээг зохион байгуулах тухай” А/116 тоот захирамжийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 7-ноос 08-ны өдрүүдэд зохион байгуулан ЗДТГ-ын албан хаагчид, Худалдаа үйлчилгээ эрхлэгчид, 9 аж ахуй нэгж байгууллагын албан хаагчид нийт 120 иргэн, ерөнхий боловсролын сургуулийн 6-12-р ангийн 518 сурагчид цэвэрлэгээнд оролцож ойр орчмынхоо 50м болон сумын төв доторх нийт 20 тонн хогийг цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт буулгасан.<br>Мөн хогийн цэгт иргэд хогоо асгах зам талбай гаргуулах ажилд Бүтээлийн нуур ХХК-тай 2022 оны 01-р сараас эхлэн гэрээ байгуулан сумын 6 га бүхий нэгдсэн хогийн цэгийн гадна талын хогийг ачих, түрэх, нүх ухах, хог буулгах талбайг гаргах ажлыг 5 удаа гүйцэтгэх явцад хяналт тавин ажилласан..Мөн хогийн цэгт иргэд хогоо асгах зам талбай гаргуулах ажилд Бүтээлийн нуур ХХК-тай 2022 оны 01-р сараас эхлэн гэрээ байгуулан сумын 6 га бүхий нэгдсэн хогийн цэгийн гадна талын хогийг ачих, түрэх, нүх ухах, хог буулгах талбайг гаргах ажлыг 5 удаа гүйцэтгэх явцад хяналт тавин ажилласан.<br>Сумын цагдаа, БОХУБайцаагч, ойн ангитай хамтран хууль бус мод бэлтгэл, байгалийн дагалт баялагийг түүх, хууль бус ан агнуураас сэргийлж 3 удаа хөдөлгөөнт эргүүл хийсэн. Оргих-Баруун гол чиглэлд хууль бус самар түүхийг завдсан 9 иргэнийг буцааж, Ноён уул, Бүдүүний гүүр, Далт, Баянхангай чиглэлд 2 удаа хөдөлгөөнт эргүүл хийж эрхийн бичиггүй загас барихыг завдсан 2 иргэнийг таслан зогсоож, буцаасан. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 99 | 3 | АЗДҮАХ-ийн 4.1.12 | ОБЕГ-тай хамтран аймгийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулах. | Хамрагдсан байгууллагын тоо | Аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургууль 06 сарын 3-5-ны өдрүүдэд “Танхимын сургалт”, “Бэлэн байдлын үзлэг”, “Штабын дадлага”, “Дадлага, сургууль” гэсэн үндсэн дөрвөн хэсэгтэйгээр явагдлаа. Штабын дадлага сургууль нь сумын нутаг дэвсгэрт хүчтэй газар хөдлөлт, малын гоц халдварт өвчин болсон үеийн удирдлагын хариу арга хэмжээ, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн анги, албадын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгох, өгөгдсөн цагийн байдлын дагуу бүлгээр ажиллах дадлагаар явагдлаа. “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн иргэдийг аюулгүй нүүн шилжих дадлага суруульд нийт 689 иргэн хамрагдсан. | 100% |
| 103 | 7 | ТАСЗ-ийн санал | Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг зохион байгуулж, төрийн албаны нөөцийг бүрдүүлэх, төрийн байгууллагуудын сул орон тоог нөхөх арга хэмжээг хэрэгжүүлэх. | Нөөцөд бүртгэгдсэн иргэдийн тоо, нөхөгдсөн сул орон тоо | Төрийн албаны сул орон тооны захиалгыг Аймгийн Төрийн албаны зөвлөлд цаг тухайд нь явуулж байна. Засаг даргын Тамгын газрын 2 албан хаагч төрийн албаны тусгай шалгалтад тэнцэн, төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагаа өргөөд байна. | 100% |
| **5.4.Ухаалаг засаглал** | | | | | | |
| **Зорилт: Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх, нутгийн захиргааны байгууллагуудын ажлын уялдааг хангах, үйл ажиллагааг үнэлж, дүгнэх зорилго бүхий цахим мэдээллийн санг ашиглалтад оруулж, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад чиг үүргийг шинжилгээ хийж, ажил үүргийг оновчтой болгон нутгийн захиргааны байгууллагуудын менежментийг сайжруулна.** | | | | | | |
| 104 | 1 | Бодлогын хэлтсийн санал | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх | Хяналт-шинжилгээ хийсэн дэд хөтөлбөрүүдийн тоо, тогтоолд заасан хугацаа | Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хяналт шалгалтын ажлын хэсэг 2022 онд суманд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр болон аймаг, сумын хөрөнгө оруулалтаар хийгдсэн 14 ажил үйлчилгээний явц, гүйцэтгэл бүрт 1-3 удаа | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хяналт тавьж, зөвлөмж хүргүүлэн ажилласан. | |
| 106 | 3 | Бодлогын хэлтсийн санал | Сумдад зөвлөн туслах ажлын хэсэг /баг/ ажиллуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний сургалтыг бүсчлэн зохион байгуулж үр дүнг тооцох. | Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн тоо | 2022 оны 02 дугаар сарын 21-ны өдөр Аймгийн Засаг даргын Тамгын газраас ажлын хэсэг ажиллаж сумын Засаг даргын Тамгын газар болон төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хяналт шалгалтын үр дүнгээр 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр аймгийн Засаг даргын захирамжаар Цагааннуур сум нь Аймгийн “Тэргүүний сум”-аар шалгарлаа. | 100% |
| 109 | 6 | САХТЖҮЧ-ийн 5.2.3 | Төрийн байгууллагын ажил үйлчилгээг цаасан суурьт болон цахим сэтгүүлээр нийтэд сурталчилах. | Хэвлэсэн сэтгүүлийн тоо | 2022 онд суманд хийгдсэн бүтээн байгуулалт, төрийн үйлчилгээ, статистик тоо мэдээллийг улирал бүр нэгтгэн гаргадаг “Нуурын мэдээ” сонины 1, 2, 3-р улирлын хэвлэлт, 2021 оны сумын жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 02 дугаар сард 1000 ширхгийг хэвлэж иргэдэд тараасан. | 100% |
| 110 | 7 | САХТЖҮЧ-ийн 5.4.3 | Төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж буй арга хэмжээнүүдийн үр нөлөөнд дотоод аудит хийх замаар эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | Орон нутгийн эдийн засгийн болон нийгмийн хүртээмжийг сайжруулах | Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон хурлын хяналт шалгалтын ажлын хэсэг 2022 онд суманд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр болон аймаг, сумын хөрөнгө оруулалтаар хөрөнгөөр хийгдсэн 14 ажил үйлчилгээний явц, гүйцэтгэлд 1-3 удаа хяналт тавьж, зөвлөмж хүргүүлэн ажилласан. | 100% |
| 111 | 8 | АЗДҮАХ-ийн 4.1.6 | Олон улсын болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллах үйл ажиллагааг өргөжүүлж, уламжлалт харилцааг бэхжүүлэн шинэ түншлэлийг нэмэгдүүлнэ. | Үр дүнтэй урт хугацааны шинэ түншлэлийг нэмэгдүүлэх | БНСУ-ын Жежү тусгай мужийн Боловсролын газар, Сэлэнгэ аймгийн БШУГ-ын хамтын ажиллагааны хүрээнд багш, сурагчдын мэдээллийн технологийн чадавхийг нэмэгдүүлэх зорилготойгоор мэдээлэл зүйн орчин үеийн тоног төхөөрөмж бүхий тохилог анги танхимаар хангагдсан. Уг ажлын үр дүнд сурагчдын мэдээллийн технологийн мэдлэг, чадвар нэмэгдэхийн зэрэгцээ багш нарын заах арга зүй | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон IT мэдлэг дээшлэх ач холбогдолтой юм. Аймгийн ХАА-н газартай хамтран хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 4 хүлэмжийг суманд аваад байна. БНСУ-н дэвшилтэт технологи бүхий ухаалаг хүлэмжийг бий болгохоор гэрээ хэлэлцээр хийгдсэн. | |
| **5.5.Хүний эрхийг дээдэлсэн нийгэм** | | | | | | |
| **Зорилт: Бүх нийтэд хүний эрхийн болон эрх зүйн боловсрол олгох, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, олон талт арга хэмжээг зохион байгуулна.** | | | | | | |
| 112 | 1 | САХТЖҮЧ-ийн 5.6 | "Иргэн таны хүний эрхийн боловсрол"-д арга хэмжээг төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх | Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | "Иргэн таны хүний эрхийн боловсролд" цахим нийтлэлийг 5 удаа цувралаар олон нийтэд хүргэж ажилласан. | 30% |
| 113 | 2 | Бодлогын хэлтсийн санал | Аймаг, сумдын Засаг дарга нарын зайлшгүй батлуулах хэм хэмжээний актыг батлан гаргаж улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах | Бүртгэгдсэн хэм хэмжээний актын тоо | Гараагүй | |
| 114 | 3 | Бодлогын хэлтсийн санал | Шинээр батлагдсан хууль тогтоомжуудаар сургалт, сурталчилгааг зохион байгуулж сум, агентлагийн холбогдох мэргэжилтнүүдийг чадавхжуулах. | Төлөвлөгөө, сургалт сурталчилгааны тоо | Иргэдийн эрх зүйн чадамжийг дээшлүүлэх зорилгоор нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын хуулийг танилцуулах сургалт уулзалтыг 2 удаа зорилтот бүлгийн иргэдэд, 1, 2, 3-р багийн өдөрлөгөөр дамжуулан Газрын тухай хууль, Татварын тухай хуулиар 615 иргэнд мэдээлэл хийхийн зэрэгцээ Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ойн дагалт баялаг, жимс жимсгэний тухай, Ан амьтны тухай хуулиар гарын авлага бэлтгэн 508 малчин өрхийн 1096 иргэнд, 46 ААН-д хүргэсэн. Мөн цахим орчноор дамжуулан Авлигын эсрэг хууль, гэр бүлийн тухай хууль, малын хулгайн тухай хуулиас 21 удаагийн нийтлэлээр танилцуулсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 115 | 4 | САХТЖҮЧ-ийн 5.6 | Хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ авах хэрэгцээ боломжийг тодорхойлох судалгааг хийж, анхан шатны хууль зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх | -Судалгаанд оролцогчдын тоо<br>-Хууль зүйн туслалцаа авсан иргэдийн тоо | Иргэдийн эрх зүйн чадамжийг дээшлүүлэх зорилгоор нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын хуулийг танилцуулах сургалт уулзалтыг 2 удаа зорилтот бүлгийн иргэдэд, 1, 2, 3-р багийн өдөрлөгөөр дамжуулан Газрын тухай хууль, Татварын тухай хуулиар 615 иргэнд мэдээлэл хийхийн зэрэгцээ Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ойн дагалт баялаг, жимс жимсгэний тухай, Ан амьтны тухай хуулиар гарын авлага бэлтгэн 508 малчин өрхийн 1096 иргэнд, 46 ААН-д хүргэсэн. Мөн цахим орчноор дамжуулан Авлигын эсрэг хууль, гэр бүлийн тухай хууль, малын хулгайн тухай хуулиас 21 удаагийн нийтлэлээр танилцуулсан. | 100% |
| **5.6.Авлигагүй засаглал** | | | | | | |
| **Зорилт: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг нийтэд түгээн иргэд, төрийн албан хаагчдад авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх хандлагыг төлөвшүүлнэ.** | | | | | | |
| 116 | 1 | САХТЖҮЧ-ийн 5.7 | Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, Олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж, шударга ёсны тогтолцоог төлөвшүүлэх ажил, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах | Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх , авлигын хор аюулыг ухуулан таниулах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Зөв зөвд шударга зөв” нөлөөллийн аянд нэгдэж аяны талаарх мэдээллийг иргэдэд цахимаар хүргэсэн. Соён гэгээрүүлэх аяны хүрээнд 12 төрлийн сурталчилгааны хуудас, 9 төрлийн зөвлөмж, 14 видео бичлэгийг сумын цахим хуудаст байршуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж, худалдан авах ажиллагааг 100 хувь цахим системээр мэдээлж байна<br>Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 3 удаагийн | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сурталтад давхардсан тоогоор 86 төрийн албан хаагч хамрагдсан | |
| 117 | 2 | САХТЖҮЧ-ийн 5.5 | “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор “Шударга удирдагч, шударга төрийн албан хаагч” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулах. | Аяны удирдамжийг гаргаж холбогдох алба хаагчдад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцох | Сэлэнгэ аймаг Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/292 дугаар захирамжаар батлагдсан “Шудрага удирдагч”, ”Шудрага төрийн албан хаагч” аян, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх сумын төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.<br>Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 17 албан тушаалтныг 02 дугаар сарын 15-ны дотор буюу хуулийн хугацаанд нь гаргуулсан. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 2 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг зохих журмын дагуу хянуулж, хянасан дүгнэлтийг албан ёсны цахим хаягт олон нийтэд ил тод, нээлттэй байршуулсан.<br>Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 3 удаагийн сурталтад давхардсан тоогоор 86 төрийн албан хаагч хамрагдсан<br>Сэлэнгэ аймаг Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/292 дугаар захирамжаар батлагдсан “Шудрага удирдагч”, ”Шудрага төрийн албан хаагч” аян, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх сумын төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.<br>Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 17 албан тушаалтныг 02 дугаар сарын 15-ны дотор буюу хуулийн хугацаанд нь гаргуулсан. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 2 этгээдийн | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг зохих журмын дагуу хянуулж, хянасан дүгнэлтийг албан ёсны цахим хаягт олон нийтэд ил тод, нээлттэй байршуулсан.<br>Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 3 удаагийн сурталтад давхардсан тоогоор 86 төрийн албан хаагч хамрагдсан.<br>“Шударга –Удирдагч, Шударга –Төрийн албан хаагч” аяны хүрээнд СӨБ болон ЕБС-ийн эрхлэгч, арга зүйч нараар дамжуулан “Багшийн ёс зүй ухамсар сэтгэлгээг өөрчлөх” сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдөр багш туслах багш нарт зохион байгууллаа. Мөн “Байгууллагын соёл-эерэг хандлага” сэдвээр сургалт нийт ажилчдад зохион байгууллаа. | |
| **ЗУРГАА.НОГООН ХӨГЖИЛ** | | | | | | |
| **Зорилго: Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| **6.1. Байгалийн баялгийн үр өгөөж** | | | | | | |
| **Зорилт: Байгальд ээлтэй, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.** | | | | | | |
| 118 | 1 | Алсын хараа-2050-ын 6.2.10, САХТЖҮЧ-ийн 6.1.1, АЗДҮАХ-ийн 3.2.7 | Ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх. | Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ га-аар | - | |
| **6.2.Үнэт баялаг ус** | | | | | | |
| **Зорилт:Усны нөөцийг хамгаалж, хуримтлал бий болгож, хомсдол бохирдлоос сэргийлнэ.** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 119 | 1 | САХТЖҮЧ-ийн 6.2.1 | Булаг шандны эхийг хамгаалж, ундарга урсацыг нэмэгдүүлэх. | Хамгаалагдсан булан шандын тоо | Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.1.1, Усны тухай хуулийн 13.1.3, 13.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс, орчмын газрын хог хаягдлыг бүрэн цэвэрлэх ажлын хүрээнд 09 дүгээр сарын 07-08-ны хооронд зохион байгуулсан. Үүнд нийгмийн халамжийн зорилтод бүлгийн иргэд Цагаан худаг, Лхамхай овооны булаг шандыг хогийг цэвэрлэж усны бохирдлыг бууруулж хамтран ажилласан. Мөн Сэлэнгэ голын ой сав, Бүдүүний гүүрний хяналтын цэгийн орчим гол бохирдуулах, хог хаях зэрэг зүй зохисгүй байдалд хяналт тавьж, хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, хог хаяхгүй байх талаар иргэд аялагчдад мэдээлэл сурталчилгаа явуулах, нөлөөллийн ажлыг орон нутагтаа байнга зохион байгуулан ажиллаж байна. Мөн сумын ЗДТГ-ын ажилтан албан хаагч, байгаль хамгаалагчид 3 км орчим хогийг түүж цэвэрлэсэн. | 30% |
| 120 | 2 | Бодлогын хэлтсийн санал | Усны үнэ цэнэ сэдэвт сургалтыг зохион байгуулах. | Зохион байгуулсан эсэх | Хэрэгжээгүй | 0% |
| 121 | 3 | Алсын хараа 2050 6.3.10, САХТЖҮЧ-ийн 6.2.2 | Хөв цөөрөм байгуулах | Байгуулагдсан хөв цөөрмийн тоо | Хэрэгжээгүй | 0% |
| **6.3. Хүртээмжтэй ногоон хөгжил** | | | | | | |
| **Зорилт: Байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 122 | 1 | Монгол | Ойн салбарын ажиллагсдын | Уулзалтад оролцсон | - | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг | чуулга, уулзалтыг зохион байгуулах. | албан хаагчдын тоо | | |
| 123 | 2 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг | Мод үржүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийг саналыг дэмжиж “Мод үржүүлэг-Ногоон байгууламж” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж үр дүнг тооцох. | Нэмэгдүүлсэн ойн талбай /га/ үр үрсэлгээний тоо, хэмжээ | Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн 0,35 сот газарт мөчрөөр болон үрээр шар хуайс 2кг, буйлс 1кг, агч 3кг тус тус үрийг тарьсан. Үүнээс буйлс 650ш, шар хуайс 9700ш, агч 8900ш нь үрсэлж ургасан байна. Ойн ангид нарс 2кг, шинэс 2кг, гацуур 2кг, шар хуайс 2кг, агч 500гр, монос 2кг, хуш 5кг Шүрэнгийн зам ХХК нь хавар 232м2 талбайд өрөл 4кг, гүйлс 500гр, тэхийн шээг 2кг, агч 1кг, голт бор 1кг, буйлс 6кг үрээр тарьж 85% ургалттай байна. Мөн нөөцөд гүйлс 13000кг, буйлс 5кг, монос 2кг, агч 2кг тарих нөөц үр байгаа. | 100% |
| 127 | 6 | Алсын хараа 2050 6.2.8, АЗДҮАХ-ийн 3.2.1 | Элсний нүүдэлд өртсөн талбайд ойн зурвас байгуулах. | Ойн зурвас байгуулсан хэмжээ /га/ | Хэрэгжээгүй | 0% |
| 128 | 7 | АЗДҮАХ-ийн 3.2.2 | Ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг ойн сан, гол хөвөөлсөн бургасанд хийх. | Тэмцэл хийсэн талбайн хэмжээ /га/ | Сумын Шүрэнгийн адаг, Мойлт нуга, Баян нуга, Эрээн хайлааст, Цог өндөр, Дээд доод хоолой зэрэг газар нутагт моносны бүгэг нийтдээ 1000 га талбайд химийн аргаар химийн бодис каратег нэг га талбайд 0.24 мл орохоор тооцоолон устгалын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хортон шавжийн устгалын ажилд багийн байгаль хамгаалагч хяналт тавин ажилласан. Хөнөөлт шавжийн үхэл буюу техникийн үрд үн 91.7 хувьтай байна. | 100% |
| 129 | 8 | АЗДҮАХ-ийн | Түймрээс хамгаалах шороон | Зурвас байгуулж | Хэрэгжээгүй | 0% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3.2.4 | зурвасын арчилгаа хийх | арчилгаа хийсэн талбайн хэмжээ /га/ | | |
| 130 | 9 | САХТЖҮЧ-ийн 6.3.6 | Зэрлэг амьтдыг хүнс, тэжээлийн хомсдолд орохоос урьдчилан сэргийлж Биотехникийн арга хэмжээ авч ажиллах. | Арга хэмжээ авч ажилласан сумдын тоо | Хэрэгжээгүй | 0% |
| 131 | 10 | Бодлогын хэлтсийн санал | “Тэрбум мод тарих хөдөлгөөн”-ийг эрчимжүүлж ногоон байгууламж, ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх. | Тарьсан модны тоо | Аймгийн Засаг даргын ”Бүх нийтээр мод тарих арга хэмжээ зохион байгуулах” ажлын хүрээнд 5,10 дугаар сард “ТЭРБУМ МОД-ЦАГААННУУР СУМ 2022” зөвлөгөөнийг сум дундын ойн ангитай хамтран зохион байгуулж Шаамар сумын мод үржүүлгийн газруудтай хамтран тарьц суулгацны үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Нийтийн эдэлбэр газарт шинээр 6 ширхэг бичил цэцэрлэг 3 га-д байгуулсан. Үүнд нарс 258 ширхэг, гоёлын мод 360 ширхэг, иргэд гоёлын мод 21 ширхэг, жимсний мод 69 ширхгийг, ААНБайгууллага гоёлын мод 82 ширхэг, жимсний мод 184 ширхгийг тус тус тарьсан байна. Сумын хэмжээнд нийт шилмүүст мод 258 ширхэг, гоёлын мод 381 ширхэг, жимсний мод 253 буюу нийт 892 ширхгийг тарьсан. | 100% |
| 132 | 11 | САХТЖҮЧ-ийн 2.5.2 | Агаар, ус, хөрсний бохирдлыг багасгаж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, ээлтэй орчинг бүрдүүлэх. | Ногоон байгууламжийн тоо | Сумын нийтийн эдэлбэр газарт шинээр 6 ширхэг бичил цэцэрлэг 3 га-д байгуулсан. Үүнд нарс 258 ширхэг, гоёлын мод 360 ширхэг, иргэд гоёлын мод 21 ширхэг, жимсний мод 69 ширхгийг, ААН-үүд гоёлын мод 82 ширхэг, жимсний мод 184 ширхгийг тус тус тарьсан. Сумын хэмжээнд нийт шилмүүст мод 258 ширхэг, гоёлын мод 381 ширхэг, жимсний мод 253 буюу нийт 892 ширхгийг тарьсан. | 100% |
| 133 | 12 | Монгол Улсын | Ойн ангиудын мэргэжлийн боловсон хүчнээр хангах, | Батлагдсан орон тоо | Сэлэнгэ аймаг дах МСҮТөвтэй Сэлэнгэ БСДОАнги Хамтран ажиллах гэрээ байгуулан | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Алсын хараа-2050-ын 6.2.4 | мэргэшүүлэх, чадваржуулах, үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх. | | "Ойжуулагч мэргэжил" - ийн нэг жилийн ангид тус сумын ойн мэргэжлийн байгууллагын гэрээт ажилтан, ойн сан гэрээгээр эзэмшигч, нөхөрлөлийн нийт 16 иргэн сурч ОЙЖУУЛАГЧ мэргэжилтэн болж чадавхжсан. | |
| **ДОЛОО.АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ** | | | | | | |
| **Зорилго: Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, орон нутгийн аюулгүй байдлыг хангана** | | | | | | |
| **7.1.Зэвсэгт хүчин** | | | | | | |
| **Зорилго: Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг ард иргэдэд сурталчилсанаар иргэдийн иргэний цэргийн үүргээ биелүүлэх мэдлэг, хандлагыг дээшлүүлнэ.** | | | | | | |
| 134 | 1 | Алсын хараа-2050 7.1.2 | Аймгийн “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний дагуу томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, бэлтгэлийг хангахад чиглэсэн сургалт зохион байгуулах. | Сургалтад хамруулахаар сонгогдсон томилгоот нэгжийн бие бүрэлдэхүүний хамралтын хувь | Аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургууль 06 сарын 3-5-ны өдрүүдэд “Танхимын сургалт”, “Бэлэн байдлын үзлэг”, “Штабын дадлага”, “Дадлага, сургууль” гэсэн үндсэн дөрвөн хэсэгтэйгээр явагдлаа. Штабын дадлага сургууль нь сумын нутаг дэвсгэрт хүчтэй газар хөдлөлт, малын гоц халдварт өвчин болсон үеийн удирдлагын хариу арга хэмжээ, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн анги, албадын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгох, өгөгдсөн цагийн байдлын дагуу бүлгээр ажиллах дадлагаар явагдлаа. “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн иргэдийг аюулгүй нүүн шилжих дадлага суруууль 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Сумын улаан загалмайн анхан шатны хороо, сумын ЗДТГ хамтран “Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр”-т зориулан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог дэмжин идэвхжүүлэх, хамтран ажиллах | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Бэлэн бай” сургалт зохион байгуулж 15 иргэн хамрагдсан. | |
| 135 | 2 | АЗДҮАХ-ийн 4.3.1 | Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах. | Эрүүлжсэн цэргийн насны залуучуудын тоо болон суурь түвшний бууралтын хувь | 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаар Цагааннуур сумын 18-25 насны нийт 45 залууг сумын Эрүүл мэндийн төвд ковид -19 цар тахлын болон урьдчилсан шинжилгээг өгүүлж Сүхбаатар суманд нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгт хамруулсан, 2 дугаар ээлжийн цэрэг татлагад 50 иргэн Сүхбаатар суманд нарийн мэргэжлийн эмч нарийн үзлэгт орсон. Эрүүл мэндээр тэнцсэн залуучууд холбогдох ангиудад цэргийн алба хааж байна.<br>2022 оны 11 дүгээр сарын байдлаар 18-25 насны давтан тоогоор 425 иргэнийг амбулаториор 117, урьдчилан сэргийлэх үзлэгээр 308 залуучуудыг үзлэгт хамруулсан. Үзлэгээр Бөөр, шээсний | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | замын өвчлөл, амьгалын зам, зүрх судасны өвчлөлтэй илэрсэн 43 залууг хэвтэн эмчлүүлсэн.<br>Урьдчилан сэргийлэх үзлэгээр 18-25 насны 308 иргэнийг элэгний В,С вирус, ДОХ/ХДХВ, зүрхний цахилгаан бичлэг, тэмбүү, заг хүйтэн, цусны дэлгэрэнгүй, шээсний Ерөнхий шинжилгээнд хамруулсан. | |
| 136 | 3 | АЗДҮАХ-ийн 4.3.1 | “Эрүүл иргэн-Энхийн манаа” сэдвийн хүрээнд идэрчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна. | Сургалтад хамрагдсан идэрчүүдийн тоо | “Эрүүл иргэн-Энхийн манаа” сэдвийн хүрээнд өсвөр насны залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх үүднээс ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдын дунд дараах сэдвүүдээр сургалт явуулсан.<br> Өсвөр насныхны эрүүл мэнд<br> Эрчүүдийн эрүүл мэнд<br> Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх.<br> Зөв зохистой хооллолт<br> Сүрьеэ өвчнөөс сэргийлэх гэх сургалтуудыг явуулсан. 12 төрлийн 2313 ширхэг гарын авлагыг сургалтад хамрагдсан иргэн болон гэрийн эргэлтээр явсан залуучуудад тараасан. | 100% |
| 137 | 4 | АЗДҮАХ-ийн 4.3.3 | Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын цогцолбор “Дөл” тэмцээнийг зохион байгуулах. | Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан хүүхэд, залуучуудын тоо | 2022 оны 1 болон 2 дугаар ээлжийн цэрэг татлагын үеэр зарлан дуудах хуудас авсан цэргийн 2 дугаар зэргийн үүрэгтэн залуучуудад цэргийн алба хаахын ач холбогдол эх оронч үзэл төлөвшүүлэх, улс орны бүтээн байгуулалтын ажилд оролцох талаар цэргийн алба хаасан залуучуудаар яриа таниулга хийх ажлыг 2 удаа зохион байгуулсан.<br>Сумын Ерөнхий боловсролын сургуулийн 10-11 дүгээр ангийн 3 бүлгийн хүүхдүүдийн дунд аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын Дөл тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр зохион байгуулсан. Бүсийн 3 сум | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Цагааннуур, Түшиг, Зүүнбүрэн сумдын ЕБС-ийн хүүхдүүдийн цэрэг спортын Дөл тэмцээнийг суманд 5 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулж Зүүнбүрэн сумын баг тэргүүн байр эзлэн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан. | |
| **7.3.Хүн, нийгмийн амар, тайван байдал** | | | | | | |
| **Зорилт: Улсын батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, хүний эх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн амар, тайван аюулгүй байдлыг хангана.** | | | | | | |
| 138 | 1 | Аймгийн ГХУСАЗЁЗ, ЦГ-ын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө | Гэмт хэрэг, зөрчил болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажилд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх. | -Гэмт хэрэг, зөрчлийн тоо | 2022 оны 10 дугаар сарын байдлаар 24 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд өмнөөх оноос 41.2%-р өссөн байна. Задлаж үзвэл хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 1, хүний эрүүл мэндэд хохирол учруулах 5, бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 1, хулгайлах гэмт хэрэг 4, залилах гэмт хэрэг 5, мал хулгайлах авилгалын 1, хууль бусаар мод бэлтэгсэн, хөдөлгөөний аюулгүй байдлын 1, бусад 2 гэсэн гэмт хэргүүд бүртгэгдээд байна | 30% |
| 139 | 2 | Аймгийн ГХУСАЗСЗ, ЦГ-ын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө | Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох олон талт ажил, арга хэмжээ зохион байгуулах. | -гэмт хэрэг зөрчлийн тоо | Сумын гэмт хэргээс урдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн гишүүд нийт 200 гаруй малчин өрхөөр явж малын хулгайгаас болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл хийж гарын авлага тараалаа.<br>Цагдаагийн байгууллагаас Улсын хэмжээнд зохион байгуулж байгаа "Мал-Мах-2022" нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 1, 2, 3 дугаар багийн 113 малчин болон мал бүхий иргэдэд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор малчдын бүлэг нөхөрлөл байгуулах хэрхэн ажиллах талаар заавар зөвлөмж өгч ажилласан.<br>2021 онд Мал хулгайлах гэмт хэрэг 6 бүртгэгдэж | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байсан бол 2022 оны 11 дүгээр сарын байдлаар хулгайлах 1 гэмт хэрэг, байгаль орчны эсрэг зөрчил 4, гэмт хэрэг 6 бүртгэгдсэн.<br>Гал түймрийн хуурайшилттай үед багийн Засаг даргатай нартай хамтран 1, 2, 3-р багийн 508 малчин өрхийн 1096 иргэнд, 46 ААН-д Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, түлээний мод бэлтгэхэд анхаарах зүйлс, Ойн дагалт баялаг, жимс жимсгэний тухай, Ан амьтны тухай хуулиар гарын авлага бэлтгэн тарааж ой хээрийн болон объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх, үнс нурмаа ил задгай асгахгүй байх, насанд хүрээгүй хүүхдийг түймрийн аюултай үед чүдэнз, асаагууртай явуулахгүй байхыг анхааруулж, гарын үсгээр баталгаажуулан авсан.<br>Сумын цагдаа, БОХУБайцаагч, ойн ангитай хамтран хууль бус мод бэлтгэл, байгалийн дагалт баялагийг түүх, хууль бус ан агнуураас сэргийлж 3 удаа хөдөлгөөнт эргүүл хийсэн. Оргих-Баруун гол чиглэлд хууль бус самар түүхийг завдсан 9 иргэнийг буцааж, Ноён уул, Бүдүүний гүүр, Далт, Баянхангай чиглэлд 2 удаа хөдөлгөөнт эргүүл хийж эрхийн бичиггүй загас барихыг завдсан 2 иргэнийг таслан зогсоож, буцаасан. | |
| 140 | 3 | Аймгийн ГХУСАЗСЗ, ЦГ-ын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын | Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, таслан зогсоооход төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, өрх, гэр бүлийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх. | -хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, энэ талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сумын төвийг тойрсон хатуу хучилттай зам дагуу 3 ширхэг нөлөөлийн самбар байрлуулсан. Самбараар дамжуулан гэр бүлийн хүчирхийлийн дуудлага мэдээллийг хүлээн авах | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төлөвлөгөө | | | утсуудыг сурталчилсан бөгөөд ингэснээр 108 дугаарын утасны талаарх иргэдийн ойлголт нэмэгдэж хүчирхийлэл үйлдэх гэж байгаа болон үйлдсэн этгээдүүдийг түргэн шуурхай илрүүлэх ажилд иргэдийн оролцоо нэмэгдээд байна. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ?, Хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэрхэн хаана хандах вэ?, Насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн хүчирхийлэл болон үе тэнгийн дарамт, дээрэлхэлт, анхан шатны тусламж хэрхэн үзүүлэх вэ? зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж 32 сурагч хамруулсан. | |
| | | **7.4.Хууль сахиулах салбарын хөгжил** | | | | |
| | | **Зорилт: Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд гаргана.** | | | | |
| 141 | 1 | ЗГҮАХ-ийн 4.3, Алсын хараа-2050 7.4, МУХҮЧ-ийн 7.3, АҮЧ-ийн 7.4 | Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг цэгүүдэд дэвшилтэт технологи бүхий камер суурилуулж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх. | -Камержуулалтын тоо | Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг цэгүүдэд Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар доторх зам дагуу 10 байршилд 16 камерыг шинээр байрлуулан сумын цагдаагийн хэсгээс хяналт тавьж ажиллаж байна. | 100% |
| 142 | 2 | ЗГҮАХ-ийн 4.3, Алсын хараа-2050 7.4, МУХҮЧ-ийн 7.3, АҮЧ-ийн 7.4 | Гэмт хэрэг, зөрчлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах боломж, нөхцөлийг дээшлүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх. | -Хохирол нөхөн төлүүлэлтийн хэмжээ | Сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нар суманд гарсан гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг тогтмол өгч уялдаа холбоотой ажиллаж байна. | 100% |
| 143 | 3 | ЗГҮАХ-ийн 4.3, Алсын хараа-2050 7.4, МУХҮЧ-ийн 7.3, | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог | -Гэмт хэргийн бууралтын тоо | Сумын гэмт хэргээс урдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн гишүүд нийт 200 гаруй малчин өрхөөр явж малын хулгайгаас болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл хийж гарын авлага тараалаа. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | АҮЧ-ийн 7.4 | нэмэгдүүлж, мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг өмнөх оны мөн үеэс 10 хувиар бууруулах. | | Цагдаагийн байгууллагаас Улсын хэмжээнд зохион байгуулж байгаа "Мал-Мах-2022" нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 1, 2, 3 дугаар багийн 113 малчин болон мал бүхий иргэдэд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор малчдын бүлэг нөхөрлөл байгуулах хэрхэн ажиллах талаар заавар зөвлөмж өгч ажилласан.<br>2021 онд Мал хулгайлах гэмт хэрэг 6 бүртгэгдэж байсан бол 2022 оны 11 дүгээр сарын байдлаар хулгайлах 1 гэмт хэрэг бүртгэгдээд байна. | |
| | | **НАЙМ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ** | | | | |
| **8.3 Тогтвортой хөдөө аж ахуй** | | | | | | |
| **Зорилт: Цаг уурын өөрчлөлтөнд дасан зохицсон цогц, ухаалаг хөдөө аж ахуйг хөгжүүлж, эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 144 | 1 | Алсын хараа-2050-ын 8.3.18, ЗГҮАХ-ийн 3.3.8, МУХҮЧ-ийн 8.3.5 | Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд зохион байгуулж, сум, баг, эрчимжсэн аж ахуй, хагас суурин өрхийг хянан баталгаажуулах. | Технологит хугацаанд зохион байгуулсан эсэх, хянан баталгаажуулсан өрхийн тоо | Засгийн газрын 255 дугаар тотоолын 1, 2, 3 дугаар хавсралтад заагдсан өвчөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулсан. Төлөвлөгөөт вакциныг Аймгийн Мал эмнэлэгийн газраас татан авч, суманд үйл ажиллагаа явуулж буй 4 МЭҮН-үүдээр дамжуулан гэрээт өрхүүдийн малыг 100 хувь хамруулан, мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөгөө гүйцэтгэл 100% оруулж хяналт тавин баталгаажуулсан.<br>2022 онд нийт гоц халдварт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт 10 төрлийн тарилгад боом 36600 толгой, галзуу 4400 толгой, гахайн мялзан 2100 толгой, адууны томуу 1600 толгой, цусан халдварт 5400 толгой, дуут хавдар 8800 толгой, тугалын иж балнад 1065 толгой, ГЦХИБ 1500 толгой, шөвөг яр 42200 толгой, бактерин 1600 толгой мал амьтан тус тус | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамруулсан.<br>Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд сумын хэмжээнд нийт 24400 толгой үхэр, шүлхий өвчний вакцинд хавар, намар 2 удаагийн тарилгаар үхэр 52105 толгой, гахай 2236 толгой, хонь 23203 толгой, ямаа 19113 толгойг хамруулсан. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад тугал 4400 толгой, хурга 23800 толгой, ишиг 16200 толгой охин төл хамруулсан.<br>Угаалгад 136100 толгой, туулгалтад 116846 толгой, боловсруулалтад 95280 толгой, гуурын боловсруулалтад 14500 толгой мал амьтан тус тус хамруулж мал эмнэлгийн цахим системд төлөвлгөө гүйцэтгэл 100% оруулж баталгаажуулсан. | |
| 145 | 2 | Алсын хараа-2050-ын 8.3.21 | Ариутгал, халдваргүйтгэл, хяналт шалгалтын нэгдсэн цэг байгуулах төсөв зардал тооцоог төлөвлөх. | Хяналт шалгалтын нэгдсэн цэг байгуулах төсөв зардал тооцоог төлөвлөсөн эсэх | - | 0% |
| 146 | 3 | АЗДҮАХ-ийн 3.1.3 | Мэргэжлийн байгууллагуудтай хамтран услах боломжтой талбайн судалгааг хийж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх. | Усалгаатай талбайн хэмжээ хувь | Усалгаатай тариалалт эрхлэх боломжтой газруудын судалгааг гаргуулан, төсөл хөтөлбөрт хамруулахаар ажиллаж байна. | 30% |
| 147 | 4 | АЗДҮАХ-ийн 3.1.5 | Хүлэмжийн болон зоорийн аж ахуйг хөгжүүлж, шинэ ургацын ногооны хангамжийг нэмэгдүүлэх. | Шинэ ногооны ургацын тариалалтын хувь | Аймгийн ХАА-н газартай хамтран хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 4 хүлэмжийг суманд аваад байна. БНСУ-н дэвшилтэт технологи бүхий ухаалаг хүлэмжийг бий болгохоор гэрээ хэлэлцээр хийгдсэн. | 70% |
| 148 | 5 | АЗДҮАХ-ийн 3.1.6 | Жимс жимсгэнэ хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, | Тариалах талбайн хэмжээ | 2022 онд Цагааннуур сумын 1 иргэний ДАЛТ-д байрлалтай жимс, жимсгэний зориулалттай 10 га | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэх. | | талбайд шинээр лийр, виноград, алим, интоорын суулгацууд суулган тариалсан.<br>Сумын хэмжээнд нийт шилмүүст мод 258 ширхэг, гоёлын мод 381 ширхэг, жимсний мод 253 буюу нийт 892 ширхгийг тарьсан. | |
| 149 | 6 | АЗДҮАХ-ийн 3.1.5 | Шинэ хөдөө төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх | Төслийн хэрэгжилтийн хувь | Хэрэгжээгүй | |
| 150 | 7 | САХТЖҮЧийн 3.5.6 | Аймгийн хэмжээнд тариалангийн талбайн тооллогыг зохион байгуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах. | Тооллогод хамрагдсан талбайн хэмжээ | Сэлэнгэ аймгийн Засаг даргын захирамжийн тариалангийн талбайн тооллого явуулах талаар Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 2 өдрийн сургалтад хамрагдсан. Мөн түүний дагуу сумын нутаг дэвсгэрт эзэмшиж буй 53,0 мян га тариалангийн талбайн бүртгэлд тулгалт хийж, аймгийн Газрын албаны мэргэжилтнүүдтэй хамтран зөрчилтэй 8 нэгж талбарт газар дээр нь хэмжилт хийж тоолж бүртгэсэн. | 100% |
| 151 | 8 | САХТЖҮЧ-ийн 3.1.2 | Газар тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлж газрын үржил шимийг сайжуулах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч үе шаттай хэрэгжүүлэх. | Дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн эсэх | Сумын газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 1 байгууллага 2022 онд газар тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлж нийт 10 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн.<br>Үүнд газар тариалангийн тоног төхөөрөмж болон үтрэмийн барилга байгууламж:<br>Үр тариа хураах зориулалттай сүүлийн үеийн комбайн техник 2 ширхэг, Үрийн буудай цэвэрлэх МЗК70 төхөөрөмж, Тээврийн хэрэгсэл /Howo чиргүүлтэй автомашин/ Будаа хадгалах, цэвэрлэх зориулалттай үтрэмийн барилга байгууламжийг тус тус үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. | 100% |
| **ЕС.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | | | | | | |
| **Зорилт: Хүн амын эрүүл орчинд, аятай тухтай амьдрах нөхцөлийг тогтвортой сайжруулна.** | | | | | | |
| 152 | 1 | АЗДҮАХ-ийн | Мандал, Баруунбүрэн сумдын | Гүйцэтгэлийн хувь | - | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3.5.13 | Спорт цогцолбор, цэнгэлдэх хүрээлэнг засварлах | | | |
| 153 | 2 | АЗДҮАХ-ийн 3.5.8, 3.5.9 | Сүхбаатар суманд төрийн үйлчилгээний төвийг барих ажлыг эхлүүлж, Баруубүрэн сумын ЗДТГ-ын барилгын ажлыг дуусгаж ашиглалтад хүлээлгэж өгөх. | Гүйцэтгэлийн хувь | - | |
| 154 | 3 | АЗДҮАХ-ийн 3.5.15 | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтад хийгдсэн ажлын явц гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах. | Хөрөнгө оруулалтаад ашиглалтад орсон барилга байгууламжийн тоо | Сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогын чиглэлийг баримтлан улсын хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, сумын төвийн замыг хатуу хучилттай болгох 6.2 тэрбум төгрөгийг батлуулж хэрэгжүүлж байна. Мөн аймгийн хөрөнгө оруулалтаар 370 сая, сумын хөрөнгө оруулалт, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 1,3 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт хийсэн. | 70% |